

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН 2021-2024 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /Арга хэмжээ/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2020 он/	Санхүүгийн эх үүсвэр /2022-2024 он/	Зорилтот түвшин /2023 он/	Хэрэгжилт	Хувь
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ: ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО.							
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: ХҮН АМЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГО							
1.1.Хүн амын бүлэг, гэр бүлийн хөгжлийн чиглэлээрх хууль, тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, шинэчлэх стратегийн зорилтын хүрээнд:							
Зорилт 1: Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	1.1. Хүн ам, хүн амын бүлэг, гэр бүлийн хөгжлийн чиглэлээрх хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, шинэчлэх	Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд: ш/ү:Судалганы тайлан	Хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийгдсэн.	Төсөв: 50.0 сая төгрөг	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох судалгаа хийсэн байна.	Хүүхдийн хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчны судалгаа, шинжилгээ үнэлгээний ажлыг хөндлөнгийн мэргэшсэн зөвлөхөөр гүйцэтгүүлж, судалгаа, шинжилгээ үнэлгээнд үндэслэн тайлан, зөвлөмж, дүгнэлтийг боловсруулсан. Тайлан, зөвлөмж, дүгнэлтэд үндэслэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төсөлд хүүхдийг бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хувьд жигд хөгжих боломжийг хангах, хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ нь хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх, Хүүхдийг гэр бүлийн орчинд бие махбод, танин мэдэхүй, нийгэмшихүйн хувьд жигд хөгжүүлэх үүргийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүлээнэ зэрэг хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээрх зохицуулалтыг тусгасан. Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн	90

					шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан УИХ-аар хэлэлцүүлж байна
	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хүрээнд: ш/ү: Хуулийн үзэл баримтлал	Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан.	Төсөв: 50.0 сая төгрөг	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, үзэл баримтлал батлагдсан байна.	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, нөхцөл байдлын судалгаа хийж тайланг хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдэд танилцуулсан. Судалгааны дүгнэлтэд үндэслэн хуулийн төслийг шинэчилсэн найруулга боловсруулахаар ХНХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, хуулийн үзэл баримтлалын төсөл боловсруулаад байгаа бөгөөд батлуулахаар хэлэлцүүлж байна.
	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх	Хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийгдсэн. Үзэл баримтлал батлагдсан	Төсөв: 17.7 тэрбум төгрөг	Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдан боловсруулсан хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан үзэл баримтлалын дагуу боловсруулж, 20 гаруй удаагийн хэлэлцүүлэг хийж, Засгийн газрын гишүүд, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн болон олон улсын байгууллага, анхан, дунд шатны салбар бүрийн нийгмийн ажилтан, 800 гаруй хүүхэд болон иргэдийн саналыг тусгасан. Хуулийн төслийг Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Монгол Улсын Засгийн газраас хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хэлэлцэхийг Улсын Их Хурлаас дэмжсэн. УИХ-ын хуулийн ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, УИХ-аар хэлэлцүүлж байна. УИХ-ын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн чуулганаар хуулийн төслийн эцэслэн хэлэлцэнэ.

		Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	Үзэл баримтлал-ын төсөл боловсруулсан.	Төсөв: 50.0 сая төгрөг	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.	<p>Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн ажлын албыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэд, аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвийг Засаг даргын Тамгын газрын дэргэд буюу Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дэргэд ажиллуулах талаар Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 378 дугаар тогтоолыг батлуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга нарт “Хамтран ажиллах тухай” 01/2828, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт “Чиглэл хүргүүлэх тухай” 01/2827 тоот албан бичгийг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хүргүүлсэн. Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн ажлын алба Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэд ажиллах болсонтой холбогдуулан ажлын албаны ажилтнуудын Албан тушаалын тодорхойлолтын төсөлд санал тусган батлуулсан.</p> <p>Мөн магадлан итгэмжлэгдсэн залуучуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах залуучуудын иргэний нийгмийн байгууллагаар залуучуудын хөгжлийн төвийн зарим ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, тэдгээр иргэний нийгмийн байгууллагыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага магадлан итгэмжлэх журмыг батлах тухай</p>
--	--	--	--	------------------------	--	---

						<p>зохицуулалтыг тус нэмэлт, өөрчлөлтөд тусгасан. Үүний хэрэгжилтийг хангах хүрээнд “Залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх залуучуудын иргэний нийгмийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ын төслийг боловсруулж, санал тусгуулахаар ХЗХДЯ, ЭМЯ, БШУЯ, Соёлын яамдад 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 01/3387 тоот албан бичгээр хүргүүлээд байна. Мөн журмын төслийг ХНХЯ-ны цахим хуудасны хууль эрх зүй-санал авч байна цэсэнд байршуулж, иргэд, залуучууд, олон нийтэд танилцуулж саналыг тусгаж байна.</p>
		<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх хүрээнд: <u>Ш/Ү:</u> - Хуулийн төсөл-1 - Холбогдох хуулиудад орох нэмэлт, өөрчлөлтийн төсөл</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулсан.</p>	<p>Улсын төсөв, Бусад эх үүсвэр</p>	<p>Хуулийн төслийг 4 дүгээр улиралд УИХ-д өргөн мэдүүлсэн байна.</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг хамтад нь батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу дээрх хуулиудын төсөл, хуулийн тандан судалгаа, үр нөлөөний судалгаа, зардлын тооцоог боловсруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг дагалдан 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан. Хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 10 удаа хэлэлцүүлсэн бөгөөд ирсэн саналыг тусган ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хамтран батлав. Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ханган ажиллаж байна.</p>

						Хуулийн III бүлэг буюу хүртээмжтэй орчин нөхцөлийн 8-12 дугаар зүйл нь Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөлд орж байгаа бөгөөд үндсэн асуудлаар шинээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сантай холбоотой 1 бүлэг, хүний нөөц бэлтгэх, төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, салбарын нийгмийн хамгааллын асуудлаар 3 зүйл нэмэгдэж, хуулийн 50-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байна.	
		Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх хүрээнд: ш/ү: - Хуулийн төсөл-1 - Холбогдох хуулиудад орох нэмэлт, өөрчлөлтийн төсөл	Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төсөл, хэрэгцээ шаардлагын судалгаа, зардлын тооцоо, үзэл баримтлалын төслийг боловсруулсан	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	Саадгүй байдал хүртээмжийн тухай хуулийн төслийг 4 дүгээр улиралд УИХ-д өргөн мэдүүлсэн байна.	“Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулсан бөгөөд 6 бүлэг, 23 зүйлээс бүрдэх юм. Хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 10 удаа хэлэлцүүлж, ирсэн саналыг тусган ажилласан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандан судалгааг эцэслэн боловсруулсан. Мөн хуулийг даган гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.	
Зорилт 1: Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	1.2 Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх	Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх	Хөтөлбөрийн төслийг боловсруулж, төр, төрийн бус байгууллагын төлөөлөлд хэлэлцүүлсэн.	Улсын төсөв, Бусад эх үүсвэр	УИХ-ын тогтоол-1	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд дунд хугацааны буюу 10 жилийн хугацаатай дараах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр заасан. Үүнд: -Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр; -Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;	90

					<p>-Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр; -Байгаль орчны зорилтот хөтөлбөр; -Засаглалын зорилтот хөтөлбөр; -Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр; -Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр.</p> <p>Эдгээр хөтөлбөрөөс “Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг “Шинэ сэргэлтийн бодлого” нэртэйгээр боловсруулж батлуулсан.</p> <p>Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг нийгмийн хөгжлийн талаарх олон улсын хэмжээнд баримталдаг ойлголт, онол, үзэл баримтлалыг судалж хэлэлцэн</p> <ol style="list-style-type: none"> 1.Хүн амын өсөлт, бүтэц 2.Өрх, гэр бүл 3.Хүнд ээлтэй орчин 4.Хөдөлмөр эрхлэлт 5.Нийгмийн хамгаалал гэсэн агуулгын хүрээнд боловсруулсан. <p>Зорилтот хөтөлбөр батлагдсаны дараа салбар бүрт зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.</p> <p>Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 57 дугаар захирамжаар, дэд ажлын хэсгийн Эдийн засгийн хөгжлийн сайдын 2022 оны А38 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Хөтөлбөрийн төслийг боловсруулан 2022 оны 7 сарын 6-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 7 сарын 8-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Гэвч Эдийн засгийн хөгжлийн яамнаас уг төслийг буцаан татаж авсан. УИХ-ын 2023 оны</p>	
--	--	--	--	--	---	--

						Намрын чуулганаар “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл”-ийг хэлэлцэхээр жагсаалтад тусгасан байгаа тул ЭЗХЯ-тай тус яам хамтран ажиллаж байна.	
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
Зорилт 1: Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.							
Зорилт 1: Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	1.3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарын нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагын чадавхи, манлайллыг бэхжүүлэх	НА-ны сургалтын цахим платформ хөгжүүлэх хүрээнд үндэсний хорооны гишүүдийг чадавхижуулсан байна. /сургалт/	Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6949:2021 стандарт батлагдсан. Нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хороо байгуулагдан ажиллаж байна.	Төсөв: 200.0 сая төгрөг	100%	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/151 дүгээр тушаалаар “Монголын Нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм”, “Монголын нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны жишиг дүрэм”-ийг тус тус батлуулсан. Дүрмийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Сургалтын хөтөлбөрийг гаргаж, төлөвлөгөөг баталсан. Нийгмийн ажилтны ёс зүйн хорооны гишүүдэд зориулсан “Ёс зүйн зөрчил, түүнийг шийдвэрлэх арга зүй” гарын авлагыг боловсруулж, хэвлүүлэхээр бэлтгэж байна. Сургалтыг 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Гарын авлагыг төлөвлөсөн хугацаанд боловсруулж, хэвлүүлсэн.	100
		Аймаг, нийслэл дүүрэгт нийгмийн ажилтны ёс зүйн салбар хороо байгуулсан хороодын тоо, шийдвэрийн хэрэгжилтийг тогтмолжуулах	Нийгмийн ажилтны мэдээллийн сан байгуулагдсан. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн салбарт нийт 1054 албан хаагч ажиллаж байна.	Төсөв: 500.0 сая төгрөг	Аймаг, нийслэл дүүрэгт ёс зүйн хороо байгуулж, шийдвэрийн хэрэгжилт 100% болсон байна.	Аймаг, нийслэл, сумдад Нийгмийн ажилтны ёс зүйн нийт 20 салбар хороог байгуулж, үйл ажиллагааны дүрмийг боловсруулан батлуулав. Ёс зүйн үндэсний хорооны 5 удаагийн хурлыг зохион байгуулсан ба салбар хороод гаргасан шийдвэрүүдээ бүрэн биелүүлж ажиллав.	

Зорилт 1: Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	1.4. Гэр бүлийг дэмжих, хамгаалах үйлчилгээг боловсронгуй болгоно.	Гэр бүлд нийгмийн үйлчилгээ үзүүлэх стандарт, арга зүйг батлуулж, үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх	Стандартын төсөл боловсруулсан	Төсөв: 50.0 сая төгрөг	Гэр бүлд нийгмийн үйлчилгээ үзүүлэх стандарт, арга зүйг батлуулж, үйлчилгээг стандартын дагуу үзүүлсэн байна.	<p>Гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага стандартын төслийг боловсруулж, батлуулахаар Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсний дагуу Стандартын техникийн хорооны гишүүдийн 2023 оны 12 дугаар сарын хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлээ.</p> <p>Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийн хүрээнд хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтны гарын авлагууд /кейс менежмент, халамжийн, сургуулийн, цагдаагийн, эмнэлгийн ажилтны болон нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний гарын авлагуудыг боловсруулж, 2023 онд үндэсний хэмжээнд зохион байгуулсан хамтарсан багийн сургалтад хэрэглэж, нийгмийн ажилтнуудад түгээв.</p> <p>Түр хамгаалах байр /ТХБ/, Нэг цэгийн үйлчилгээний төв /НЦҮТ/ нь “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нийтлэг шаардлага” MNS 6040:2019 стандартын дагуу үйлчилгээ үзүүлж ажиллав. Улсын хэмжээний 36 ТХБ, НЦҮТ-өөр 2023 оны байдлаар нийт 4037 иргэнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлснээс 729 насанд хүрэгч, 3308 хүүхэд, үүнээс 505 хүүхэд, 67 насанд хүрэгч урт хугацаагаар байрлаж аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээнд хамрагдсан. Эдгээр хамгаалах байрны үйлчилгээний зардалд Хүүхэд хамгааллын зардлаас 2023 онд 1,1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх онтой харьцуулахад 1,6 дахин өссөн байна.</p>	70
		Гэр бүлд зөвлөгөө өгөх сургалт,	2021 онд Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн	Төсөв: 500.0	35%	2023 оны байдлаар 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хэмжээнд Гэр бүлд зөвлөгөө өгөх 30 төв ажиллаж, нийт 43541 иргэн, 35778 насанд	

		үйлчилгээнд Үйлчлүүлсэн хүний тоо, нийт гэр бүлд эзлэх хувиар	сургалтад нийт гэр бүлийн 20 хувийг хамруулсан.	сая төгрөг		хүрэгч, 6697 хүүхэд, 21878 гэр бүлд хөгжил, хамгааллын үйлчилгээ үзүүлснээс 8554 иргэнд ганцаарчлан болон бүлгээр, хосоор зөвлөгөө өгч, 48302 хүнийг сургалтанд хамруулж, 3157 иргэнийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилж, эрүүл мэнд, сэтгэл засал, нийгмийн халамж, эрх зүйн тусламж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн.	
		Etuslamj.mn мэдээллийн сангийн ашиглалтын хувь	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний Etuslamj.mn мэдээллийн санг хөгжүүлсэн.	Төсөв: 200.0 сая төгрөг	-Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлсэн үйлчилгээний бүртгэлийг нэмэлтээр хөгжүүлсэн байна. - Ашиглалтын хувь 90%	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 21 дүгээр зүйлд 21.1-д заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг хүлээсэн байдаг. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 36 Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүчирхийллийн хохирогчийг Etuslamj.mn мэдээллийн санд бүртгэлжүүлж байна. Харин тус мэдээллийн санд түшиглэн “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлсэн үйлчилгээний бүртгэлийг нэмэлтээр хөгжүүлэх”-ээр тусгасан боловч Дэлхийн зөн ОУБ-аас зарласан тендэр удааширсантай холбоотой одоогоор хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна.	
		Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр шинэчлэх шаардлагатай 3 журам, 1 удирдамж	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагаж гарсан 32 журам, 1 стандарт хэрэгжиж байна.	Төсөв: 50.0 сая төгрөг	3 журам, 1 удирдамжийн төслийг батлуулсан байна.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан 32 журам, 1 стандарт батлагдан хэрэгжиж байна. Үүнээс 2023 онд ХНХС, ХЗДХС, ЭМСайдын 2017 оны А/173, А/251, А/3801 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”, ХНХС, ХЗДХСайдын 2017 оны А/120, А/178 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан “Түр	

						хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлыг тооцох журам"-ыг шинэчлэн батлуулахаар төслийг боловсруулан хамтран батлах яамд руу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/1075 албан тоотор хүргүүлсэн боловч Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцэгдэж байгаатай холбогдуулан түр хүлээх чиглэлийг ХЗДХЯамнаас ирүүлсэн. УИХ-аас Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр батлаад байна. Иймд эдгээр журмыг тус хуультай нийцүүлэн батлуулна. Мөн Түр хамгаалах байрнаас Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчин бүрдүүлэх удирдамжийг боловсруулж, батлуулахад бэлтгэсэн. НҮБ-ын Хүн амын сангаас Ази Номхон далайн бүсийн жөндөр хариуцсан мэргэжилтнээс санал авах хүргүүлсний дагуу Түр хүлээгдэж байна.	
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3: ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
Зорилт 1. Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.							
Зорилт 1: Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	1.5. Эрүүл насжилтыг дэмжих, ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний цогц загварыг туршиж нэвтрүүлэх	Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээг турших 3 төв сонгон хэрэгжүүлэхэд шаардлагатай: -нөөц, чадавхийг	АХБ-ны Олон нийтийн оролцоонд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээний төслийг хэрэгжүүлж эхэлсэн.	Төсөв (АХБ) 500.0 мянган доллар	-Шаардлагатай нөөц, чадавхийг тодорхойлох үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулсан байна. -Төвд шаардлагатай тоног төрөөхөмжөөр хангасан байна.	Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загварыг туршин нэвтрүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам хамтран 3 зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааны чиглэлтэй "Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/127, А/333 дугаар хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Тусламж, үйлчилгээ үзүүлэх цогц загварын хүрээнд ахмад настанд үзүүлэх тусламж	90

		<p>тодорхойлох үнэлгээ, -Тоног төхөөрөмж</p>				<p>үйлчилгээний төрлүүдийг тодорхойлох зорилгоор Кейс менежментийн онол практикт тулгуурлан Монгол Улсад тохирсон “Идэвхтэй насжилтыг дэмжих төв”-ийн үйл ажиллагааны удирдамжийн төслийг дараах чиглэлээр боловсуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Кейс менежерийн болон ахлах кейс менежерийн ажлын байрны тодорхойлолт; • Кейс менежментийн бүтэц • Олон нийттэй холбогдох тохиолдлыг илрүүлэх; • Эрсдэлийн илрүүлэг, ангилал; • Кейс менежментийн үйлчилгээнд бүртгэн, баримтжуулах; • Эрсдэлтэй ахмад настанд хэрэгцээний цогц үнэлгээ хийх; • Тусламж үйлчилгээний төлөвлөгөө боловсруулах, хянах; • Багийн хурал; • Үйлчлүүлэгчийг шилжүүлэх; • Тусламж үйлчилгээг зогсоох зэрэг юм. <p>Түүнчлэн ахмад настнуудад түгээмэл тохиолддог 31 төрлийн доройтлын үед эмнэл зүй, нийгэм сэтгэл зүй, санхүүгийн үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх тухай 31 зааврын төслийг боловсруулан, туршилтаар хэрэгжүүлж байна.</p> <p>Төсөл хэрэгжүүлж буй 3 байгууллагад нийт 65,565,000 төгрөгийн шаардлагатай тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Үүнд:</p> <p>-Ачлалт хүүхдүүд төрийн бус байгууллагад нийт 24,325.0000 төгрөгийн 18 төрлийн 56 ширхэг;</p> <p>-Дархан-Уул аймгийн ахмадын хөгжлийн төвд нийт 17,715.000 төгрөгийн 10 төрлийн 29 ширхэг;</p>	
--	--	--	--	--	--	---	--

						-Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэгдсэн эмнэлэгт 23,525.000 төгрөгийн 111 ширхэг тоног төхөөрөмж.	
		Шинэ төрлийн үйлчилгээний зураглал			Шинэ төрлийн үйлчилгээний зураглалыг баталсан байна.	Кейс менежментийн ерөнхий заавар, үүнд кейс менежерийн үүрэг, ажлын байрны тодорхойлолт, багийн бүтэц, олон нийттэй ажиллах, идэвхтэй болон идэвхгүй кейс илрүүлэг, эрсдэлийн илрүүлэг, ангилал, кейс баримтжуулах, бүртгэх, хэрэгцээний цогц үнэлгээ, тусламж үйлчилгээний төлөвлөгөө боловсруулах, олон мэргэжлийн багаар ажиллах, үйлчлүүлэгчийг шилжүүлэх, үйлчилгээг төгсгөх тухай нийт 10 удирдамж боловсруулан туршилтаар хэрэгжүүлж байна.	
		Сонгосон орон нутгийн үйлчилгээнд хамрагдсан ахмад настны эзлэх хувь			Сонгосон орон нутгийн нийт ахмад настны 40-өөс доошгүй хувьд үйлчилгээ үзүүлсэн байна.	Идэвхтэй насжилтыг дэмжих төвөөр 2023 онд давхардсан тоогоор 14,555 ахмад настанд үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс: -Ачлалт хүүхдүүд төрийн бус байгууллагаар Сонгинохайрхан дүүргийн нийт ахмадын 1.8 хувь; -Дархан-Уул аймгийн ахмадын хөгжлийн төвөөр аймгийн нийт ахмадын 95 хувь; -Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийг түшиглэн байгуулсан төвөөр сумын нийт ахмадын 10 хувь.	
1.6. Хүүхэд хамгаалалд зориулсан зардлыг одоогийн хүрсэн түвшнээс бууруулахгүйгээр цаашид нэмэгдүүлэн, үр дүнд	Хүүхэд хамгааллын зардлын хэмжээ, тэрбум төгрөгөөр	Улсын төсвөөс хүүхэд хамгааллын арга хэмжээнд 2019 онд 7,6 тэрбум, 2020 онд 8 тэрбум төгрөг зарцуулсан. Хүүхдийн эрхийн асуудлаар нийт	Төсөв: 5.2 тэрбум төгрөг	Хүүхэд хамгааллын зардлын хэмжээ 8,0 тэрбумаас багагүй байна.	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын 8 тэрбум төгрөгийн төсвийг нэмэгдүүлж Хүүхэд хамгааллын нийт зардлыг 14.3 тэрбум төгрөгөөр 2024 оны төсвийн төсөлд тусгасан. Энэ нь 2023 оны төсвөөс 6.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.	100	

	суурилсан санхүүжилтийг олгох, зарцуулалтын үр ашгийг сайжруулах		15 стандарт батлагдсан.				
	1.7. Хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх	Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулсан хүүхдийн тоо, эзлэх хувь	Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 31 асрамж, халамжийн төвд 1031 гаруй хүүхэд амьдарч байна.	Төсөв: 500.0 сая төгрөг	100%	<p>-21 аймаг, 9 дүүрэгт Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээнд 38377 хүүхэд, 38134 эцэг эхчүүд хамрагдсан.</p> <p>-Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ 301 цэгт хүрч очиж ажилласан ба эрх нь зөрчигдсөн 1537 хүүхдийг илрүүлж, 912 хүүхдийг хүүхэд хамгааллын байгууллага бусад байгууллагад холбон зуучилсан. Зарцуулсан төсөв: 7,100,000 төг</p> <p>-Гэр бүлд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээнд тавигдах стандарт, гэр бүлд чиглэсэн зорилтот үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хэмжээнд Гэр бүлд зөвлөгөө өгөх 29 төв ажиллаж 63 нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн ба нийт 17,708 иргэн, 15,738 насанд хүрэгч, 1970 хүүхэд, 1458 гэр бүл хамрагдсан байна. Хамрагдсан иргэдийн 80,4%-д хөгжлийн үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>Монгол Улсын хэмжээнд 02-18 насны хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээ үзүүлдэг асрамж, халамжийн 31 төвд нийт 974 хүүхэд амьдарч байна.</p>	70
		Хүүхэд харах үйлчилгээний стандартын	Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг стандарт MNS6540:2015,	Хүүхэд харах үйлчилгээний стандар	Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг стандарт MNS6540:2015 -	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж буйтай холбогдуулан стандартын шинэчилсэн найруулга боловсруулах ажлыг хууль батлагдах хүртэл хойшлуулах	

		төсөл /шинэчлэх/	Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг стандарт MNS5852:2017	тыг шинэчлэн боловсруулж, үйлчилгээг стандартын дагуу үзүүлсэн байна. Төсөв: 1.5 тэрбум төгрөг	ын төслийг шинэчлэн боловсруулж Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний нэг төрөл болгон батлуулсан байна.	шаардлагатай тул 2023 онд шинээр батлах стандартын жагсаалтаас хасах хүсэлтийг Стандартчилал хэмжил зүйн газарт албан тоотой хүргүүлсэн.	
		Хууль зүйн хорооны гишүүдийг чадавхижуулах	ХНХ-ын сайд, ХЗДХ-ийн сайд нарын хамтарсан тушаалаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журам батлагдаж, 30 Хууль зүйн хороо байгуулагдаж, 958 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн.	Төсөв: 269.0 сая төгрөг	Хууль зүйн хорооны гишүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулсан байна.	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо аймаг, дүүрэг, сум дундын шүүхтэй сумдад байгуулагдаж, 38 хороонд 522 гишүүн хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу ажиллаж байна. -2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай уулзалт хийж, журмын хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг, чиглэлийг өгсөн. Энэ дагуу Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны Ажлын алба /Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/-ыг чадавхижуулах “Ментор хөтөлбөр”-ийг 11 аймаг, 4 дүүрэгт хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд ажлын албаны гишүүдийг чадавхижуулах сургалтыг 1 удаа, 11 аймаг, 4 дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн Хорооны гишүүдийг чадавхижуулах сургалтыг 1 удаа, аймаг, дүүргийн Хууль зүйн хороо, Ажлын албыг ажлын байран дээр чадавхижуулах, зөвлөн туслах үйл ажиллагааг тус тус зохион байгуулсан.	

					2023 онд 1871 хүүхдэд хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлсэн нь хүүхдийн кейс шийдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс 15 хувиар өссөн үзүүлэлт юм.
	Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажиллах дүрмийг шинэчлэн боловсруулах	Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрхтэй 49 албан хаагч 94 хүүхдийн эрхийн зөрчил шалган шийдвэрлэсэн.	Төсөв:15 0.0 сая төгрөг	Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрмийг шинэчлэн боловсруулсан байна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төслийг дагалдан Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төслийг Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх зүйн байдал, чиг үүргийг шинэчлэн тодорхойлж, дүрмийг Засгийн газар батлах зохицуулалтыг шинээр тусгасан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, даган боловсруулсан хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн эцсийн хэлэлцүүлэг УИХ-ын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэнэ. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрмийн төслийг шинэчлэн боловсруулж, улсын байцаагчдын дунд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.
	Чадавхжуулах сургалтад хамрагдсан хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хөдөлмөрийн хяналтын улсын	“Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”, “13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл,	Төсөв:20 5.0 сая төгрөг	Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг чадавхижуулах сургалт зохион байгуулсан байна.	Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Хүүхдийн эрхийн улсын байцаагчид болон Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нийт 150 албан хаагчдыг 2023 оны 06 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд чадавхжуулах сургалтад хамруулсан. 2023 онд Хүүхдийн эрхийн улсын байцаагч 677 объектын шалгалт хийж, 21 хүүхдийг илрүүлж, Хүүхэд, гэр бүлийн хөгжил,

		байцаагчдын тоо	хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл"-ийг баталсан.			хамгааллын ерөнхий газар, хэлтэс холбон зуучилсан байна. Мөн 677 байгууллагад Хүүхэд хамгааллын бодлого, дүрмийг мөрдөн ажиллах зөвлөмж өгсөн.	
1.8. Хүүхдийн ордон, театр хөгжлийн төвүүдийг нэмэгдүүлж, хөгжлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	"Олон Улсын хүүхдийн Найрамдал-2"	зуслангийн төв байрны барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	Бүртгэлтэй 42 зуслан байгаагаас үйл ажиллагаа явуулж буй 35 зуслан байна. Улсын 14, хувийн 23, ОНӨҮГ 5 байна. Нийслэлд 15, орон нутагт 20 зуслан байна. "Олон Улсын хүүхдийн Найрамдал-2" зуслангийн зураг төсөл батлагдсан, тендер баримт бичиг боловсруулсан . "Олон Улсын хүүхдийн Найрамдал-2" зуслангийн стратегийг батлуулсан. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа	Улсын Төсөв: 30.0 тэрбум төгрөг	Төв байрны барилгын ажлын гүйцэтгэл хувь. 40	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар "Олон улсын Хүүхдийн Найрамдал-2" төсөл арга хэмжээний барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. Тус тендерийн үнэлгээний хороо нээлттэй тендер шалгаруулалтын 2 удаа зарласан боловч оролцох сонирхсон этгээд тендер ирүүлээгүй үндэслэлээр хүчингүй болсон. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/129 дүгээр тушаалаар Олон улсын хүүхдийн Найрамдал-2 зуслан байгуулах төсөл арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий салбар дундын ажлын хэсэг шинэчлэн байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хуралдааныг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр ажлын хэсгийн ахлагч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл нар удирдан зохион байгуулж, холбогдох албан тушаалтан, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний болон барилгын зураг, төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгч хугацаатай үүрэг, даалгаврыг өгч, хэрэгжилт, үр дүнгээ ажлын хэсэгт танилцуулахыг чиглэл болгов.	50

		Хүүхдийн хөгжлийг дэмжиж санхүүжүүлсэн хөтөлбөрийн тоо	Ерөнхий стандарт MNS5633:2019	Улсын төсөв: 50.0 тэрбум төгрөг	10-аас доошгүй хөтөлбөр сонгон шалгаруулж, улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.	<p>2023 онд 42 зуслан үйл ажиллагаа явуулж, зуслангийн хөгжлийн хөтөлбөрт 73964 хүүхэд хамрагдсан.</p> <p>Зуслангийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, 1237 хүүхэд, “Эх орон-36” хөтөлбөрт 200, Хүүхдийн ардын урлагийн бэсрэг наадамд 150, Майхант цугларалтад 400, Үндэсний чуулганд-750, Хамтдаа инээмсэглэе тусгай хөтөлбөрт-100 хүүхдийг хамруулж, нэгдсэн арга хэмжээг зуслангийн хөгжлийн хөтөлбөртэй хамтатган зохион байгуулж нийт 3715 хүүхэд хамруулсан.</p> <ol style="list-style-type: none"> 1. Тус яамны санхүүжилтээр хүүхэд хөгжлийн “Эх орон-36” хөтөлбөрийг Батлан хамгаалах яамны харьяа “Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ болон Цагдаагийн Ерөнхий газрын харьяа “Сүүж-Уул” амралт, сувиллын газарт 2023 оны 07 дугаар сарын 24-нөөс 08 дугаар сарын 03-ны өдрийн хооронд зохион байгуулж, 200 хүүхдийг хамрууллаа. 2. Тусгай хэрэгцээт хүүхдүүд тэдний эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан “Оролцоод хөгжье” зуны тусгай ээлжийн хөтөлбөрийг “Анар” хүүхдийн зусланд 6 сарын 20-ны өдрөөс 07 сарын 02-ны өдрийг хүртэл зохион байгуулсан. Тусгай ээлжийн хөтөлбөрт 100 хүүхэд, 100 эцэг эх, асран хамгаалагчийг 4 ээлжээр тус бүр 3 хоног хамруулсан. 3. “Зуслангийн мэдээллийн сан судалгааны тайлан”-г үндэслэн зорилтот бүлгийн хүүхдийг зуслангийн хөгжлийн хөтөлбөрт тэгш хамруулах арга хэмжээг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулсан. Нийт 1,237 хүүхэд хамрагдав. Үүнд:
--	--	--	-------------------------------	---------------------------------	---	---

						<ul style="list-style-type: none"> - Төвийн бүс: Дархан-Уул аймгийн “Зулзагын гол” зусланд 2023 оны 06 сарын 20-ны өдрөөс 25-ны өдрүүдэд нийт 280 хүүхэд; - Баруун бүс: Завхан аймгийн “Даян-Очир” зусланд 2023 оны 06 сарын 22-ны өдрөөс 27-ны өдрүүдэд нийт 228 хүүхэд; - Говийн бүс: Дундговь аймгийн “Бүрдийн уянга” зусланд 2023 оны 06 сарын 23-ны өдрөөс 27-ны өдрүүдэд нийт 220 хүүхэд, - Зүүн бүс: Нийслэлийн Баянгол дүүргийн “Баянгол” зусланд 2023 оны 06 сарын 25-ны өдрөөс 29-ны өдрүүдэд нийт 200 хүүхэд; - Хангайн бүс: Баянхонгор аймгийн “Өвгөнжаргалант” зусланд 2023 оны 07 сарын 01-ний өдрөөс 05-ны өдрүүдэд нийт 268 хүүхэд; - Нийслэлийн бүс: ОУ-ын хүүхдийн Найрамдал цогцолборт 9 дүүргийн 41 хүүхэд оролцуулж, зохион байгуулав. <p>4. “Эх оронч сурагч” зорилтот төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын сурлага, сахилга, урлаг, спортоороо манлайлсан ахлах ангийн 40 сурагч хамрагдав.</p>	
1.9. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийт, иргэний нийгмийн	- Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн тоог нэмэгдүүлэх хүрээнд: Улсын хэмжээнд	Улсын хэмжээнд нийт 4300 байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулагдсан.	Төсөв: 200.0 сая төгрөг /2024 онд/	100%	2023 онд шинээр 756 байгууллага хүүхэд хамгааллын бодлого баталж, 1011 байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулж, 107 байгууллага хүүхдийн өрөө тохижуулж, 7 байгууллага хүүхдийн цэцэрлэгтэй болж албан хаагчдын хүүхдүүдэд ээлтэй орчин бүрдүүлсэн. Хүүхэд хамгааллын бодлого баталсан 9 яам байна. -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам -Барилга, хот байгуулалтын яам; -Хууль зүй, дотоод хэргийн яам;	90	

	оролцоог нэмэгдүүлэх	5362 эцэг, эхийн зөвлөл байгуулах; -Эцэг, эх, олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг 7 аймаг, 2 дүүргийн 7242 ААНБ-д сургалт зохион байгуулах				<p>-Боловсрол, шинжлэх ухааны яам; -Соёлын яам; -Зам, тээврийн хөгжлийн яам; -Батлан хамгаалах яам; -Эрчим хүчний яам; -Эрүүл мэндийн яам.</p> <p>-2023 оны байдлаар Улсын хэмжээнд 2660 байгууллага, аж ахуй нэгж “Хүүхэд хамгааллын бодлого” баталж, 6374 байгууллага, аж ахуйн нэгж “Эцэг эхийн зөвлөл”-өө байгуулж, 629 байгууллага хүүхдийн өрөө тохижуулж, 75 байгууллага дэргэдээ хүүхдийн цэцэрлэг байгуулан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн.</p>	
		2023 оны 8-р сард “Хүүхдийн эрхийг дээдэлъе” хүүхдийн оролцооны үндэсний чуулган зохион байгуулах	-	Төсөв: 44.0 сая төгрөг ОУБ-с /2023 онд/	100%	<p>“Хүүхдийн эрхийг дээдэлъе” уриан дор 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр “Монголын хүүхдийн оролцооны үндэсний чуулганыг зохион байгуулж, хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллагын төлөөлөл 700 гаруй хүүхдийг оролцуулж, Төрийн ордонд зохион байгууллаа.</p> <p>Чуулганы хүрээнд хүүхдийн эрүүл мэнд, амьдрах орчин, хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийн талаарх үндсэн 5 хэсэг хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, гарсан санал, санаачилгыг нэгтгэн уриалга гаргасныг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүллээ.</p>	
	1.10. Аймаг, дүүргүүд дэх Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлүүд болон салбарууд	Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг	Улсын хэмжээнд 436 Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулагдаж 7000 орчим залуучууд	Төсөв: 45.0 сая	Шийдвэрийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	<p>“Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийг баталж, улсын хэмжээнд Залуучуудын хөгжлийн нийт 436 зөвлөл байгуулагдаж, 7 мянга гаруй залуучууд гишүүнээр бүртгэгдээд байна. Үүнд 21 аймаг, 9 дүүрэг, 56 сум, 124 хороо, 13 яам, агентлагийн дэргэд 78 зөвлөл, төрийн болон ААНБ-ын дэргэд 133 зөвлөл,</p>	70

	дахь Залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	100 хувь хангана.	хүсэл сонирхлоороо нэгдээд байна.			сонирхлын 3 зөвлөл байна. Мөн шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог хангах зорилго бүхий Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд ахалж, аймаг, дүүргүүдэд Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлүүд ажиллаж, орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцсэн Залуучуудын хөгжлийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд: нийт 339 сум, 9 дүүрэгт Залуучуудын салбар зөвлөлүүд байгуулагдан ажиллаж байна.	
	1.11. Залуучуудын хөгжлийн төвүүдийн үйлчилгээний чанар, хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлэх	Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээнд хамрагдагчдын тоог нийт залуучуудын 45 хувьд хүргэх	Бүх аймаг, дүүрэг, Өмнөговь аймгийн 5 суманд, нийт 35 Залуучуудын хөгжлийн төв ажиллаж жилд үйлчилгээнд нийт залуучуудын 40-42 хувийг хамруулж байна.	Төсөв: 160.0 сая төгрөг	Үйлчилгээнд хамруулсан 15-34 насны залуучуудын тоо, нийт залуучуудын тоонд эзлэх хувь 47% байна.	Аймаг, дүүрэг, зарим сумдын Залуучуудын хөгжлийн 43 төвөөр 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 414007 залуучууд буюу 15-34 насны нийт залуучуудын 41 хувь нь хамрагдаж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан залуучуудын хөгжлийг дэмжих 7 төрлийн үйлчилгээ авсан байна.	90
		Залуучуудын хөгжлийн төв /ЗХТ/-ийн үйлчилгээний стандартын батлуулах	Стандартын төслийг боловсруулж, ЗХТ-үүд, бусад холбогдох талуудаар 2 удаа хэлэлцүүлсэн.	Төсөв: 10.0 сая төгрөг	Стандартыг батлуулсан байна.	Залуучуудын үйлчилгээний төвийн үйлчилгээний стандартын төсөл болон хүүхэд, өсвөр үеийн хөгжил, хамгааллын бусад холбогдох стандартын төслийг боловсруулж холбогдох хороогоор хэлэлцүүлснээр "Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төв, үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 7012:2023 стандарт"-ыг батлуулсан. Стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд ЗХТ-үүдэд стандартын шаардлагыг хангаж буй байдалд үнэлгээ хийх, үнэлгээнд үндэслэн стандартын	

					шаардлагыг хангахад шаардагдах арга хэмжээний хөтөлбөр, хөрөнгө оруулалтын төсөвлөлтийг боловсруулах арга хэмжээг 2024 оны 1 дүгээр улиралд хэрэгжүүлнэ.	
	Цахим үйлчилгээ /сэтгэл зүй, хууль зүйн зөвлөгөө, эрүүл мэнд, бусад зөвлөгөө, үйлчилгээ/-нд хамрагдсан залуучуудын хувь	Залуучуудын хөгжлийн төвийн сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээг цахимаар хүргэж байна.	Төсөв: 70.0 сая төгрөг	Цахим үйлчилгээнд хамрагдсан 15-34 насны залуучуудын тооны өсөлтийн хувь 13%.	Залуучуудын хөгжлийн төвийн арга хэмжээ, үйлчилгээг цахимжуулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн санал санаачлага, хамтын ажиллагааг дэмжих хүрээнд “Юнител” групптэй хамтран “Unitel hub” цахим сургалт, мэдээллийн цэгийг зарим аймагт байгуулж, орон нутагт зохион байгуулах сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулж, 12 аймгийн 22 сургагч багш, залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүдийг хамруулсан. Эдгээр сургагч багш нар цаашид орон нутгийн өсвөр үе, залуучуудад кодчилолын анхан шатны мэдлэг, электроны элементүүдийг таньж, ажиллах зарчмын талаар мэдлэг эзэмшүүлэхийн зэрэгцээ цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, анхаарлаа төвлөрүүлж сурах, нягт нямбай ажиллагаанд суралцах, багаар хамтран ажиллах, зорилготой болох, харилцааны чадвар эзэмших зэрэг зөөлөн ур чадварыг олгох юм. “Unitel hub” танхимаар өсвөр үе, залуучууд үйлчлүүлснээр дээрх сургалтуудад хамрагдахаас гадна суурин компьютер, ухаалаг таблет, өндөр хурдны интернет ашиглан кино үзэх /IPTV/, ном унших, сонсох зэрэг хөгжлийн үйлчилгээг авах боломжтой бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар сургалт, мэдээллийн болон бусад арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 7811 хүүхэд, залуучуудыг хамруулсан.	
1.12. Залуучууды	Залуучуудын хөгжлийн	Залуучуудын оролцооны		Чуулганд оролцогч	Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд хөгжлийн үндэсний чуулганыг угтаж, 3 шатны	100

	<p>н иргэний нийгмийн байгууллагудын санал, санаачлагыг дэмжих, төр, иргэний нийгмийн байгууллагудын хамтын ажиллагааг сайжруулах</p>	<p>арга хэмжээнд оролцох, хамтран ажиллах иргэний нийгмийн байгууллагуудын тоог нэмэгдүүлж, залуучуудад чиглэсэн бүтээлч үйл ажиллагааг хэрэгжүүлэх</p>	<p>бүлгэм, клубыг аймаг, дүүргийн ЗХТ-ийн дэргэд ажиллуулж байна. Залуучуудын хөгжлийн үндэсний чуулганыг жил бүр зохион байгуулж, дунджаар 600-800 залуучуудыг хамруулж байна.</p>	<p>Төсөв: 90.0 сая</p>	<p>залуучууд, ИНБ-ын тооны өсөлтийн хувь 13%.</p>	<p>хэлэлцүүлгийг 08 дугаар сард дараах байдлаар зохион байгуулав. Үүнд: 1.Залуучуудын иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл; 2. Хувийн хэвшил дэх залуучуудын төлөөлөл; 3. Яамд, салбар зөвлөлийн гишүүд, төрийн байгууллагын залуучуудын төлөөлөл. Эдгээр хэлэлцүүлэгт нийт 84 залуучууд танхимаар, 102 залуучууд цахимаар оролцож Залуучуудын үндэсний болон салбар зөвлөлийн дүрмийн өөрчлөлт; Сайн дурын ажилтан бүртгэх, баталгаажуулах журмын өөрчлөлт; Магадлан итгэмжлэх журмын төсөл; Тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэхэд залуучуудын иргэний нийгмийн байгууллагын хувь нэмрийн талаар хэлэлцэж, санал, шүүмж, дүгнэлтийг нэгдсэн чуулганы зөвлөмжид тусгасан. Мөн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан мэдээлэл өгөх, санал солилцох, зөвлөлдөх уулзалтыг залуучуудын иргэний нийгмийн байгууллагууд, аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн удирдлагууд, Залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүдтэй 2023 оны 06-07 дугаар сард зохион байгуулж оролцоог дэмжсэн. “Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход залуучуудын бүтээлч хамтын оролцоо” залуучуудын хөгжлийн үндэсний 9 дүгээр чуулганыг Монголын залуучуудын өдөр буюу 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулж, төрийн, иргэний нийгмийн, олон улсын байгууллагын зочид, төлөөлөгчид, залуучууд олон нийтийн төлөөлөл танхимаар 680, цахимаар 4500 гаруй залуучууд оролцож, залуучуудын өмнө</p>
--	---	---	---	------------------------	---	--

						тулгамдсан эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөгжих эрх, нийгмийн оролцооны асуудлыг хэлэлцэж, чуулган угтсан дэд хэлэлцүүлгүүд, чуулганы үндсэн болон салбар хэлэлцүүлгээр дэвшүүлсэн санал, шүүмжийг нэгтгэн 7 чиглэл бүхий зөвлөмжийг залуучуудын иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс төрийн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.	
1.13. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах	Хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдах хүний тоо 5410	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2020 оны байдлаар 2844 хүн хамрагдаж, 1089 хүн байнгын ажлын байртай болсон.	Улсын төсөв	Хөтөлбөр арга хэмжээнд 5410 хамрагдаж 2700 байнгын ажлын бий болгож 11,2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт нийт 5479 иргэн хамрагдаж, 10,501,815,300 төгрөгийг зарцуулсан. Үүнээс: <ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээнд 80 иргэн хамрагдаж 800,000,000 төгрөгийг; • Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1106 иргэн хамрагдаж, 7,348,000,000 төгрөгийг; • Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 884 иргэн хамрагдаж, 159,142,300 төгрөгийг; • Борлуулалтын болон түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 626 иргэн хамрагдаж, 190,204,650 төгрөгийг; • Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 21 иргэн хамрагдаж 234,942,500 төгрөгийг; • Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаанд төгрөгийг 1,600,000,000 тус тус зарцуулсан байна. 	100	
1.14. Дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийг сайжруулж, хөгжлийн	Хүртээмжтэй дэд бүтцийн болон Мэдээлэл техноги, харилцаа холбооны	Барилга байгууламж, зам, нийтийн тээвэр, зогсоол зэрэг дэд бүтцийн хүртээмжийн,	Төсөв (АХБ) 53 800 000	-Барилга байгууламжийн үнэлгээ- 5 -Мэдээллийн хүртээмжийн үнэлгээг 5 цахим	Түгээмэл хөгжил төв ТББ-тай хамтран Чингэлтэй дүүргийн дараах байршлуудад явган хүний зам талбайн дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээг MNS 6055:2009, MNS 6808:2019 стандартын дагуу хийсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Төв шуудан - Цэцэг төв 	90	

	<p>бэрхшээлтэй хүн нийгмийн бүх харилцаанд бүрэн дүүрэн эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх</p>	<p>хүртээмжийн үнэлгээ, судалгаа хийх</p>	<p>хаягжилт, угтах үйлчилгээ, цахим хуудас, телевиз зэрэг мэдээллийн хүртээмжийн чиглэлээр үнэлгээний ажлыг 2015 оноос эхлэн төр, төрийн бус байгууллага хамтран хийж, холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.</p>		<p>хуудсанд хийсэн байна.</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол банк - Монголын ипотекийн корпорац - Үндэсний түүхийн музей - Цаг уур орчны шинжилгээний газар - Нийслэлийн Засаг Захиргааны 4 дүгээр байр - Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг - Үндэсний түүхийн музей - Чингис хаан музей - Нэгдүгээр дэлгүүрийн уулзвар - СУИС-ийн уулзвар <p>Үнэлгээний тайлангийн дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Чингэлтэй дүүрэгт хүргүүлсэн. 2023 оны 10 дугаар сарын 26, 27-ны өдөр Түгээмэл хөгжил ТББ-тай хамтран Монголын хүүхдийн ордон, Спортын төв ордонд дэд бүтцийн үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч боловсрох, спортоор хичээллэхэд барилга байгууламжийн дэд бүтцийг MNS 6055:2009, MNS 6808:2019 стандартын шаардлагын дагуу төлөвлөх, гадна хаяг, орц гарц, налуу зам, үүдний босго, бариул, гэрэлтүүлэг зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх, байгууллагуудын багш ажилтан албан хаагчид дохионы хэлний мэдлэгтэй байх, туслах ажилтан ажиллуулах зэрэг шаардлагатайг тусгасан.</p> <p>Мөн 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 20-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 17, 23, 37, 49, 65, 72, 76, 107, 138, 149, 153 дугаар сургуулиудын барилга байгууламжид MNS 6055:2009, MNS 6808:2019 стандартын дагуу дэд бүтэц, хүртээмжийн үнэлгээг хийж,</p>	
--	--	---	--	--	-------------------------------	--	--

					<p>арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.</p> <p>Мэдээллийн хүртээмжийг сайжруулах хүрээнд И-Монголиа академи УТҮГ-тай хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүн И-Монголиа системд нэвтэрч төрийн үйлчилгээг хүртээмжтэй авах боломж бүрдүүлэн ажиллаж байна. Харааны бэрхшээлтэй, сул хараатай, гэрэлд мэдрэг, сурахад хэт мэдрэг зэрэг хүнд зориулсан тусгай хүртээмжийн тохиргоог гар утсанд суулгах И-Монголиа аппликейшнд нэвтрүүлсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэх авах цэс нэмж оруулсан. 2022 онд ХБХХЕГ-аас ЦХХЯ, И-Монголиа академийн ажилтнуудад хөгжлийн бэрхшээлийн ойлголт хандлагын хичээл ордог байсан бол 2023 онд И-Монголиа академи нь 308 хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцаж тэдэнд аппликейшн хэрхэн хэрэглэх сургалт оруулсан бөгөөд ХУРдан үйлчилгээ нэвтрүүлж ТҮЦ үйлчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэрэгтэй үйлчилгээг хүргэн ажиллаж байна. МУИС-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Ярьдаг, сонсдог номын сан ашиглалтанд оруулсан, бичдэг үзэг, томруулагч, компьютерт суурилуулсан апп болон брайль төхөөрөмж, дэлгэц зэргийн тусламжтайгаар хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд хүртээмжтэй орчинд хичээл давтах өрөө, номын сантай болсон.</p>	
		Сургалт, нөлөөллийн арга хэмжээг нэгдсэн		-	<p>Сургалт, нөлөөллийн арга хэмжээг 20-оос доошгүй удаа</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг албан хаагчдыг чадавхжуулах сургалт болон хөгжлийн бэрхшээлийн талаарх нөлөөллийн сургалтыг 2023 онд 10 гаруй удаа нийт 1020 хүнд хийсэн.</p>	

		байдлаар хийх			<p>зохион байгуулсан байна.</p> <p>“Бэрх биш ээлтэй-2” аяныг 2023 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл нийт 3 сарын хугацаатай 2 үе шаттай зохион байгуулж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Ялгамж бүтээж, аяны өнгө төрхийг тодорхойлох; 2. Нөлөөллийн аяныг үндэсний хэмжээнд зохион байгуулах; 3. Тайлан мэдээлэл өгөх. <p>Аяны хүрээнд бэрх биш ээлтэй пэйж хуудас ажиллуулж олон нийтийн хандалт авч постер, контент бүтээж байршуулж байгаа бөгөөд УБ хотын томоохон самбарт постер байршуулахаас гадна автобусны зогсоолын сурталчилгааны самбаруудад уриалсан постерууд гаргаж төлөвлөгөөний дагуу нийгмийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн ойлголтыг түгээж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд уриалж байна. 2023 оны 12 сарын 13-нд эхний явцын тайлан хүлээн авсан. Тайланд Аяны логоны шинэчлэлт, Фото зураг авалт болон иллюстраци зураг, график зураг, Контент бүтээгчдийн контентүүд (HumanZ, Medq media agency, Molpedia, Youtuber Uyanga, Kino zadlan), FB болон INSTAGRAM Постерууд, Мэдээ, мэдээллийн сайт болон сувгууд (UB.LIFE, URUG.MN, PLAYMO, NOOROG), хэвлэмэл сурталчилгааг CCTS болон Лифт самбаруудад байрлуулан хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгардаг асуудлуудыг хөндөж, нийгмийн хандлагыг илүү эерэг бөгөөд ээлтэй байлгах, ХБИ-дэд зориулсан хүртээмжтэй орчныг бүрдүүлж аюулгүй амьдрах нөхцлөөр хангахад хүн бүрийн</p>	
--	--	---------------	--	--	--	--

					оролцоо чухал гэдэгт олон нийтийг уриалсан байна.	
		-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв, -Сургалт	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн хөгжлийн төвийн барилгын зураг төслийг баталсан.	6 Улсын төсөв, АХБ (28,5 тэрбум төгрөг)	-Архангай аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулсан байна. -Төвүүдэд ажиллах хүний нөөцийг бэлтгэсэн байна.	-Архангай аймагт баригдаж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв"-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 65 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд гүйцэтгэгч ЖАМ ХХК болон Мотоблок ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа дууссан тул гэрээг дүгнэж, үлдэгдэл ажлын тооцоог хийж, шинээр сонгон шалгаруулалт хийх бэлтгэл ажлыг хангаж байна. -Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд хүүхдийн эрт үеийн хөгжлийн боловсролын Портеж хөтөлбөр, хүүхдийн хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хэл засал, сул хараа, туслах технологи, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах нийгмийн ажилтнуудын чадавх бэхжүүлэх чиглэлээр нийт 9 удаагийн сургалтаар 268 сэргээн засахын ажилтнуудыг бэлтгэсэн.
		ш/ү: 6 төвийн бүтэц, орон тоо, Төвийн дүрмийг батлуулах	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дүрэмд заасны дагуу бүтэц, орон тоог бүрдүүлж ажилласан байна.	Засгийн газрын 2021 оны 164 дүгээр тогтоолоор 6 аймагт "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийг "Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын тухайн орон нутаг дахь салбар хэлбэрээр байгуулсан. "Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/159 дүгээр тушаалаар баталсан. Уг тушаалын 4 дүгээр хавсралтаар Орон нутаг дахь салбар төвийн бүтэц, зохион байгуулалтыг, тавдугаар хавсралтаар орон нутгийн салбар төвийн ажлын байрны үлгэрчилсэн жагсаалтыг, зургаадугаар

					<p>хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дүрмийг тус тус баталсан. Дархан-уул, Дундговь, Ховд, Хөвсгөл, Дорнод аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв орон нутагт сэргээн засахын үйлчилгээ хүргэж байна.</p> <p>Орон нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг тус бүр 30 байхаар заасан бөгөөд үүнээс: Дархан-Уул аймаг 17, Дундговь аймаг 26, Ховд аймаг 22, Хөвсгөл аймаг 27, Дорнод аймаг 27, Архангай аймаг 1 (Төвийн дарга). Тус бүр нээлттэй сонгон шалгаруулалт зарлан албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагын дагуу хүний нөөцөө бүрдүүлэн ажиллаж байна.</p>		
		Улаанбаатар хотод Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн төвийн барилгын гүйцэтгэлийн хувь	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилга угсралтын ажлыг 60-аас доошгүй хувьд хүргэсэн байна.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн барилгын гүйцэтгэл гэрээний дагуу 80 хувьтай байна.	
		ХБИ-ийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Төвийн дүрмийн төсөл	-	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дүрмийн төслийг боловсруулсан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн нэгдсэн төвийн дүрмийн төсөл боловсруулсан.	

ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 2: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1: ХӨДӨЛМӨРИЙН АСУУДЛААРХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГО

<p>Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.</p>	<p>2.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжин, тэнцвэрийг хангах</p>	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж гарах дүрэм, журам, аргачлалуудыг батлуулах</p>	<p>УИХ-ын 1999 онд баталсан “Хөдөлмөрийн тухай хууль”, хуулийг дагаж гарсан дүрэм, журам, аргачлал</p>	<p align="center">-</p>	<p>Хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж гарах 9 дүрэм, журам, аргачлалыг батлуулсан байна.</p>	<p>Хөдөлмөрийн тухай хууль 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын тогтоолоор 5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар 8, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны тогтоолоор 7 нийт 20 дүрэм, журам, аргачлалыг шинээр болон шинэчлэн батлуулсан байна.</p> <p>2023 онд Хөдөлмөрийн тухай хуулийн 147.3-т заасны дагуу “Хөдөлмөрийн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах журам” болон “Хөдөлмөрийн арбитрын дүрэм”-ийг Засгийн газрын 2023 оны 04, 05 дугаар тогтоолоор, “Хөдөлмөрийн зуучлагчийн ёс зүйн дүрэм”, “Хөдөлмөрийн арбитрчийн ёс зүйн дүрэм”-ийг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2023 оны 03 дугаар тогтоолоор тус тус батлуулсан. Мөн Хөдөлмөрийн зуучлагч, хөдөлмөрийн арбитрчдын нэрсийн жагсаалтыг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2023 оны 04, 05, 08, 09 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан.</p> <p>Хөдөлмөрийн тухай хуулийн 28.1-д “Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журам сахиулах зэрэг хүн амд нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг байгууллагын ажилтан, албан хаагч эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ байгуулахыг санаачлах эрхтэй боловч ажил хаялт санаачлах, зохион байгуулах, түүнд оролцохыг хориглоно. Нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг Үндэсний хорооны саналыг харгалзаж Засгийн газар батална.”</p>	<p align="center">70</p>
---	---	--	--	-------------------------	---	---	--------------------------

						<p>гэж заасан. “Нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ын төслийг боловсруулан, яамдаас, ажил олгогчдын төлөөллийн байгууллагаас санал авсан. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны санал хүлээгдэж байгаа тул Засгийн газраар батлуулах ажил хойшлоод байна.</p> <p>на. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 28.5.-д “Цахилгаан, дулааны эрчим хүч, нийтийн усан хангамж, олон улс, хот хоорондын болон хот, суурин газрын нийтийн тээвэр, цахилгаан холбоо, төмөр зам болон иргэний нисэхийн хөдөлгөөний албаны аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагч ажил хаях, ажлын байр түр хаах /локаут/-ыг санаачлах, зохион байгуулах, түүнд оролцох эрхтэй. Эдгээр байгууллагаас хүн амд үзүүлэх наад захын үйлчилгээний хэмжээг Үндэсний хорооны саналыг харгалзан Засгийн газар батална.” гэж заасан. “Үйлчилгээний хэмжээ батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас, ажил олгогчдын төлөөллийн байгууллагаас санал авсан. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны санал хүлээгдэж байгаа тул Засгийн газраар батлуулах ажил хойшлоод байна.</p>
		Хууль болон түүнийг дагаж гарсан дүрэм, журам, аргачлалыг олон нийтэд		-	Хууль болон түүнийг дагаж гарсан дүрэм, журам, аргачлалыг олон нийтэд танилцуулах	“Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд ажилтан, ажил олгогчдын оролцоо” сургалт, хэлэлцүүлгийг Завхан, Говь-Алтай, Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Дундговь, Баян-Өлгий аймгийн төлөөллийг оролцуулан 2023 оны 10-11 дүгээр сард зохион байгуулж, ажилтан, ажил

		танилцуулах сургалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах			сургалтыг 3 бүсэд зохион байгуулсан байна.	олгогч байгууллагуудын нийт 250 төлөөллийг хамруулав. - Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ/ ажил олгогчдод зориулсан “Хүүхэд, гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцаа” гарын авлагыг 2023 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр боловсруулан, аж ахуйн нэгж, байгууллага хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлдэг эсэх талаарх судалгааг хийж, 90 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч, хүний нөөц, захиргааны ажилтнуудыг хамруулсан сургалтыг 3 удаа зохион байгуулсан.
		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг шинэчлэн найруулах хүрээнд: -Хуулийн үзэл баримтлал-1,	Хууль зүй, дотоод хэргийн Сайдаар батлуулахаар ХЗДХ-ийн яаманд 2022 оны 01 дүгээр сард 01/219 тоот, 07 дугаар сард 01/1861 тоот албан бичгээр тус тус 2 удаа хүргүүлсэн. Засгийн газрын бүтэц,	Улсын төсөв	2023 оны II улиралд багтаан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлалыг ХЗДХ Сайдаар батлуулсан байна. -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэлэлцүүлгийг 8 удаа зохион	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлалыг хамтран батлахаар 2023 оны 12 сарын 01-ний өдрийн 01/3132 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Мөн хуулийн төсөл, зардлын тооцоог боловсруулан Засгийн газарт өргөн мэдүүлэхээр бэлэн боллоо. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зохицуулалтыг тусгаж байна. Үүнд: - Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг, урамшуулал олгохоос гадна ажлын байрыг хадгалах, хамгаалах, ялангуяа эдийн засгийн болон бусад давагдашгүй хүчин зүйлийн улмаас бий болдог хямралын үед хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг

		- Хэлэлцүүлэг- 8 -ХЭДТХууль -1	бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг ХЗДХЯ-нд дахин хүргүүлэхээр ажилласан		байгуулсан байна. - III улиралд багтаан Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн бүрдүүлбэрийг ханган Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн байна.	Ажилгүйдлийн даатгалын тухай болон бусад хууль тогтоомжтой уялдуулан тусгах, - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих суурь нөхцөлийг бий болгохоор хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн ойрын, дунд, хэтийн хугацааны судалгааг холбогдох аргачлалын дагуу хийж, дүн, мэдээг иргэдэд түгээх замаар мэргэжил сонголтыг зөв, оновчтой хийх боломжийг дэмжих зохицуулалтыг тусгах, -Хөгжлийн бэрхшээлтэй хүн, залуучууд, эмэгтэйчүүд болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зохицуулалт хийх, дэмжлэгийн төрөл, хэлбэрийг хуульд нарийвчлан тусгах; бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хүрээнд нэр томьёог боловсронгуй болгож, холбогдох дэмжлэг, урамшууллыг оновчтой, уялдаатай, шаталсан байдлаар тодорхойлох, бизнес инкубацын үйлчилгээг орчин үеийн чиг хандлагад нийцүүлж үзүүлэх зэрэг дэмжлэг, үйл ажиллагааг хуульд тусгах зэргээр боловсруулж байна.	
		Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийг дагалдан дүрэм, журмын Засгийн газрын тогтоол-2	-	Улсын төсөв	1.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д “Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөхтэй	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д заасны дагуу “Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Монгол Улсад 2023-2025 онуудад шаардлагатай нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг аж үйлдвэрийн IV хувьсгал, мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн динамик өөрчлөлт, олон улсын хөдөлмөрийн чиг хандлага болон өмнөх жилүүдийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажиллах хүчний статистик мэдээлэл болон “Шинэ сэргэлтийн бодлого”-	

				<p>холбоотой журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулан Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсаны дараа Засгийн газрын хуралдаанаар II дугаар улиралд багтаан батлуулсан байна.</p> <p>2.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 21.3.3 -т заасан нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хоёр жил тутамд 10 дугаар сарын 01-ний дотор Засгийн газар батална” гэж</p>	<p>д туссан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд гадаадаас авч ажиллуулах зайлшгүй шаардлагатай нарийн мэргэшлийн мэргэжилтний талаарх судалгаа зэрэгт тулгуурлан, холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн дэргэдэх 35 гаруй мэргэжлийн зөвлөлүүд, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон бусад оролцогч талуудаас саналуудыг нэгтгэн боловсруулж, яамдуудаас санал авч 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 359 дүгээр тогтоолоор 11 эдийн засгийн ангиллын 130 нарийн мэргэшлийн жагсаалтыг батлуулсан.</p> <p>Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг баталснаар уг жагсаалтад заасан мэргэшлийн гадаад ажилтанг авч ажиллуулахад Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.9-д заасан зөвшөөрлийг нэмэлт шаардлагагүй авах эрх зүйн орчин бүрдсэн.</p>	
--	--	--	--	--	--	--

					заасны дагуу тогтоолын төслийг IV улиралд батлуулсан байна.	
		“Гадаад ажилтныг Монгол Улсад ирсэний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ын төслийг боловсруулж, хамтарсан сайдын тушаалаар батлуулах	-		“Гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журмыг эрүүл мэндийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална” гэж заасны дагуу журмын төслийг I дүгээр улиралд багтаан батлуулсан байна.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 24.6-д заасны дагуу "Гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журам"-ыг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/483,А/220 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. Журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэл бүртгүүлэхээр Эрүүл мэндийн яамны 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 3/19 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн болно.
		4 журмын төслийг боловсруулж, ХНХ-ын Сайдын тушаалаар батлуулах	-	-	Хуулийг дагаж гарах “Гадаад ажилтан зуучлах үйлчилгээ үзүүлэх”, “Зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх цахим систем ашиглах”, “Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх,	Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл хүссэн 45 байгууллагын баримт бичгийг цахимаар болон цаасаар хэлбэрээр хүлээн авсан. Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу байгууллага бүрийн ирүүлсэн баримт бичгийн бүрдэлтийг хуулийн дагуу нягтлан шалгаж, тухай бүр нөхөн ирүүлэх талаар мэдэгдсэн. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар тус яамныТөрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг 4 удаа хуралдаж, Ажиллах хүчний шилжилт

				<p>хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэл хөтлөх” 3 журмыг II дугаар улиралд багтаан батлуулсан байна.</p> <p>“Гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний журам” Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно.” хэсэгт нийцүүлж хүчингүй болсонд тооцохоор тусгасан байна.</p>	<p>хөдөлгөөний тухай хуулийн шаардлага хангасан 24 байгууллагад тусгай зөвшөөрөл олгох дүгнэлт гаргаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулсан.</p> <p>Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийт 71 байгууллагад Монгол Улсын иргэнийг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Япон Улсад тус тус зуучлах тусгай зөвшөөрөл олгосон. Шаардлага хангаагүй байгууллагуудад тухай бүр хариуг хүргүүлсэн.</p> <p>Салбарын Хяналтын газартай хамтран тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн байгууллагуудад Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн холбогдох шаардлага хангасан эсэхэд магадлан шалгахаар үйл ажиллагаатай нь танилцаж, Ажлын хэсгийн хуралд танилцуулсан. Түүнчлэн Монгол Улсаас Унгар Улсад суугаа Элчин сайдын яамнаас ирүүлсэн өргөдлийн дагуу Монгол Улсын иргэнийг тусгай зөвшөөрөлгүй Унгар Улсад зуучлах үйлчилгээ эрхэлж байсан Хутагт Мөрөн ХХК-ийн үйл ажиллагаанд Салбарын Хяналтын газартай хамтран хяналт, шалгалт хийж холбогдох арга хэмжээг авсан.</p> <p>Тусгай зөвшөөрөл олгосон 71 байгууллагад 2024 оны 1 дүгээр улиралд хяналт-шалгалт хийхээр Салбарын Хяналтын Газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан.</p>	
--	--	--	--	---	--	--

ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖЛЫН БАИРЫГ ДЭМЖИХ БОДЛОГО

	<p>2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний нэгдсэн стандартыг нэвтрүүлж, олон улсын жишигт нийцүүлэх</p>	<p>Улсын хэмжээнд хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд Үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэвтрүүлнэ.</p>	<p>2020 онд Үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг 6 аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд туршиж эхэлсэн.</p>	<p>Төсөв: 77,8 сая</p>	<p>-Үйлчлүүлэгч-төвтэй хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээ"-ний загвар, аргачлал, зөвлөмжийг ОУ-ын зөвлөх ажиллуулж боловсруулсан байна. -14 аймаг, дүүргийн ХХҮГ/Х-т үйлчилгээний заал, сургалтын өрөө, ажил мэргэжлийн зөвлөгөөний өрөө байгуулсан байна. ХБИ-д хүртээмжтэй байхаар зам талбайг засч, зориулалтын тоноглолоор тохижуулсан байна.</p>	<p>Европын холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн Зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд “Үйлчлүүлэгч төвтэй” хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээг нэвтрүүлэхээр загвар, аргачлал, зөвлөмжийг боловсруулахад олон улсын төслийн 8 үндсэн зөвлөх, 31 бүсийн зөвлөх авч ажиллуулсан. Үйлчлүүлэгч төвтэй аргачлалыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлж эхэлсэнтэй холбогдуулан ажилгүй болон ажил хайгч, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай иргэнийг хувь хүний хэрэгцээнд үндэслэн профайлинг буюу хөдөлмөр эрхлэх чадварыг үнэлэх зорилт тавин улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Дээрх үйлчилгээг хэрэгжүүлэхээр 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага Монгол Улсад ажилгүй байгаа нийт иргэдийн ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодруулах, мэдээллийн сан үүсгэх зорилгоор нийт 50 мянган ажилгүй иргэнд хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдлын үнэлгээг хийх хүрээнд 2022 онд 14 мянган иргэнд, 2023 онд 21,870 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдлын үнэлгээг хийж хөдөлмөрийн</p>	<p align="center">90</p>
--	---	--	--	----------------------------	---	--	--------------------------

						зах зээлд нэвтрэх төлөвлөгөө гаргаж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2024 онд 14 мянган иргэнд хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Түүнчлэн 2023 онд “Үйлчлүүлэгч-төвтэй” Хөдөлмөр эрхлэлтийн /профайлинг/ үйлчилгээ буюу Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээний цэсийг “ejob” платформд хөгжүүлсэн. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг 21 аймаг, 9 дүүрэгт байгуулан заал, ажил мэргэжлийн зөвлөгөөний өрөөг тохижуулан, тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан. Мөн Баянчандмань ПК-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй сургалтын орчинг тохижуулж, тохируулгатай тоног төхөөрөмжөөр хангасан.	
Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж,	2.3. Хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг сайжруулж, тогтвортой ажлын байрыг бий болгоход дэмжлэг үзүүлэх	Нэг жилд 40 000-с доошгүй иргэнийг хамруулах	2020 онд хүн амын бүлгүүдэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээнд давхардсан тоогоор 30547 иргэн хамрагдсан.	Улсын төсөв	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 56.3 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 56776 иргэнийг хөтөлбөр, арга хэмжээнд хамруулсан байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд нийт 58098 иргэн хамрагдаж, 52,175,687,264 төгрөгийг зарцуулж 33844 ажлын байр бий болж хадгалсан байна. Үүнээс үйл ажиллагаа тус бүрээр авч үзвэл: -Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд 21608 иргэн хамрагдаж, 1,608,037,137 төгрөгийг зарцуулж, 2320 ажлын байр бий болсон; -Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 7324 иргэн хамрагдаж, 31,371,064,879 төгрөгийг зарцуулж, 5817 ажлын байр бий болсон; -Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 5479 иргэн хамрагдаж, 10,501,815,300 төгрөгийг зарцуулж, 1396 ажлын байр бий болсон; -Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд 23687 иргэн хамрагдаж, 8,694,769,948	100

ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ						төгрөгийг зарцуулж, 24311 ажлын байр тус тус бий болж хадгалсан байна.	
	2.4. Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа нарийн мэргэжлийн өндөр ур чадвартай мэргэшсэн гадаадын мэргэжилтэнд дотоодын ажиллах хүчнийг дагалдуулан сургах	Гадаад мэргэжилтний 30 хувьд нь дотоодын ажиллах хүчийг дагалдуулж мэргэшүүлэх	-	Улсын төсөв	Гадаад ажилтанд дотоодын ажилтанг дагалдуулах нь 30 хувь байна.	Монгол Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Чуулганы нэгдсэн хуралдаанаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хуулийг мөрдөж эхэлсэн. Тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Засгийн газар тогтооно” гэж заасны дагуу “Монгол Улсад 2023 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 359 дүгээр тогтоолоор 20351 гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгохоор баталсан. Үүний дагуу 2023 онд нийт 19611 гадаад ажилтанд зөвшөөрөл өгч Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлсэн байна. Мөн хуулийн 22.4-т “Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төв, орон нутгийн захиргааны байгууллага энэ хуулийн 24.1-д заасан ажил олгогчтой	90

						бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээ байгуулж хэрэгжүүлнэ. Дагалдан сургах ажилтны хувь хэмжээ нь тухайн ажил олгогчийн гадаад ажилтны 30 хувиас доошгүй байна.” гэж заасан. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 03/1387 тоот албан бичгээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн. 2024 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон аймгийн засаг дарга нарын хооронд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний төсөлд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4-т заасны дагуу тухайн ажил олгогчийн гадаад ажилтныг дагалдан сургах, ажилтны хувь хэмжээг 30 хувиас доошгүй байлгахад анхаарч хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгасан болно.	
2.5. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, “Халамжаас-Хөдөлмөрт” хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж жилд дунджаар 25000 иргэн шинээр ажилд оруулах	-	Улсын төсөв	-25000 шинэ ажлын байр бий болгосон байна. -56776 иргэнийг хөтөлбөр, арга хэмжээнд хамруулсан байна.	Улсын хэмжээнд 2023 онд нийт 36138 ажлын шинэ байр бий болж, түүнд ажилгүй иргэдийг бүрэн байршуулсан байна. Тайлант хугацаанд нийт 36138 ажлын шинэ байрыг бүртгэж тухайн ажлын байранд ажилд орсон иргэдийн мэдээллээр баталгаажуулсан байна. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл 8748 хүнээр буюу 32.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100	
2.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтын	Чадамжийн санг 2022, 2023, 2024 онуудад үе шаттайгаар	“Мэргэжлийн сургалтын байгууллагыг	Чадамжийн санг 2022, 2023, 2024	Чадамжийн санг үе шаттайгаар хөгжүүлэлт хийж, олон нийтэд нээлттэйгээр	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 17.4 дэх хэсэгт “Хүний мэргэшлийн түвшинг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал		

	тэгш хүртээмжийг нэмэгдүүлэн, иргэдийн хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлж насан туршийн суралцахуйг дэмжих	хөгжүүлэлт хийх	бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”	онуудад үе шаттайгаар хөгжүүлэлт хийгдэнэ.	цахимаар байршуулсан байна.	эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулж, 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Мэргэжлийн зөвлөл, сургалтын 30 гаруй байгууллагын төлөөллүүдийн дунд хэлэлцүүлсэн байсан ч Монгол Улсын Их Хурлаар Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан. Тус хуулийн 8.3-т “Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасан. Энэ хүрээнд тус журмын төслийг боловсруулан хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг тусгаж ажилласан болно. “Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журам”-ын төсөл, тушаалын төслийг эцэслэн боловсруулж дуусч санал авахаар БШУЯ-нд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 01/2546 дугаар албан бичгийг хүргүүлээд байна.	50
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3: ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ БОДЛОГО							
Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ							
Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн	2.7. Цалин хөлсний тогтолцоо, зохицуулалтыг боловсронгуй болгох	Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалин 10-аас багагүй хувиар нэмэгдүүлэх	Төсөвт байгууллагын ажилтны сарын дундаж цалин 1053.4 мян.төгрөг	Улсын төсөв: 52.0 тэрбум төгрөг	Төрийн албан хаагчдын цалинг 10 хувиас багагүй нэмэгдүүлсэн байна.	Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны 488 дугаар тогтоолоор үндсэн цалинг мөрдөгдөж байсан цалингийн шатлалын хамгийн өндрөөр нь тогтоон нэг шатлалтай болгосон. Үр дүнд нь 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс төрийн захиргааны 1-4 дүгээр шатлалын цалингаар цалинжиж байсан 14 мянга орчим, төрийн тусгай албаны 40.7 мянга орчим албан хаагчийн цалин 12-15	100

орлогыг нэмэгдүүлнэ .		Төрийн захиргааны болон тусгай алба хаагчдын цалингийн шатлалыг 1 болгох		Улсын төсөв: 120.0 тэрбум төгрөг		хувь нэмэгдсэн. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 9-ны 452 дугаар тогтоолоор цагдаа, дотоодын цэргийн албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн баталж, цалингийн 5 шатлалыг 1 болгосон. Үүний үр дүнд 12.0 мянга орчим цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдын цалин дунджаар 30 хувиар нэмэгдсэн. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын хүрээнд Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дунджаар 40 хувиар нэмэгдүүлэн тогтоолоо. Уг арга хэмжээний хүрээнд төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин 26.0-31.0 хувиар нэмэгдсэн. (2023 оны 1 дүгээр сарын 01-нээс 8 хувиар нэмэгдсэн).
		Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн төрд ажилласан жил бүрийг үнэлж нэмэгдэл олгох журам	ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”	Улсын төсөв: 50.0 тэрбум төгрөг	“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.	Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д өөрчлөлт оруулан баталсан. Төрийн захиргааны болон үйлчилгээний албанд анх ажилд орсон албан хаагч тасралтгүй 5 жил ажилласны дараагаас ажилласан жилийн нэмэгдэл авч эхэлдэг байсныг өөрчилж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг жил бүрээр бодож олгодог байхаар холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Үр дүнд нь 160.0 мянган төрийн албан хаагчийн цалин хөлс 2-5 хувиар нэмэгдэж, төрийн албанд чадварлаг албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах зарчмыг хэрэгжүүлэх боломж нэмэгдэнэ.
	Орон нутагт ажиллаж байгаа	ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоол	Улсын төсөв:	“Төрийн үйлчилгээний албан хаагчид	Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралтаар баталсан	

		төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам	“Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”	15.0 тэрбум төгрөг	орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.	<p>“Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний орон нутгийн нэмэгдэл олгохоор болсон. Түүнчлэн аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө төрийн захиргааны албан хаагчид олгох орон нутгийн нэмэгдлийг 80 хүртэл хувиар нэмэгдүүлэх боломжтой байдлаар холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ арга хэмжээнд орон нутгийн 12 мянга орчим төрийн захиргааны албан хаагчид хамрагдаж байна.</p> <p>Мөн Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 242 дугаар тогтоолоор Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p> <p>Уг тогтоол батлагдсанаар босоо удирдлагатай буюу улсын төсвөөс санхүүждэг байгууллагын төрийн захиргааны албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг орон нутгийн төсвөөс нэмж авах боломж бүрдсэн.</p> <p>Мөн орон нутгийн нэмэгдэл авч чадахгүй байсан хөдөө, орон нутгийн соёлын байгууллагын зарим албан хаагчид, аймгийн төвийн суманд ажиллаж байгаа ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын албан хаагчид болон хөдөө сумдад ажиллаж буй ус,</p>
--	--	---	--	--------------------	--	---

						цаг уурын өртөө, харуулын албан хаагчид, улсын тусгай хамгаалалттай газрын туслах байгаль хамгаалагчид 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 8-20 хувийн нэмэгдэл авах боломжтой болсон.	
		Төрийн захиргааны албаны 15 зэрэглэлийг 10 болгон нягтаршуулах	ЗГ-ын 2019 оны 275 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай”	Улсын төсөв: 20.0 тэрбум төгрөг	Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг 10 болгон шинэчилсэн байна.	Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны 488 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ нь 15 зэрэглэл тус бүрт 3-5 шатлалтай, төрийн тусгай албаны цалингийн сүлжээ нь 18 зэрэглэл тус бүрт 3-5 шатлалтай буюу нийт 153 ялгаатай цалинтай байсныг өөрчлөн төрийн захиргааны албан тушаалын 15 зэрэглэлийг 10, тусгай албаны 18 зэрэглэлийг 13 болгон нягтаршуулсан.	
		Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420.0 мян.төг (сар)	30%: Улсын төсөв: 43.8 тэрбум төгрөг 10%: Улсын төсөв: 18.5 тэрбум төгрөг	ХХДХ-г 30 хувиас багагүй нэмэгдүүлсэн байна.	Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 130 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэг цагт 3273 төгрөг 80 мөнгө буюу сард 550.0 мянган төгрөг байхаар тогтоосон. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны 12 дугаар тогтоолоор 20 хувиар нэмэгдүүлэн 2024 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн сард 660.0 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоосон. Ингэснээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2020 онд 420.0 мянган төгрөг байсантай харьцуулахад 1.57 дахин нэмэгдсэн байна.	
Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар	2.8. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлол тод дүн шинжилгээ	ҮАМАТ-08-д дүн шинжилгээ хийн, шаардлагатай ажил, мэргэжлээр нэмэлт,	НХХС-ын 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “ҮАМАТ-ын жагсаалт, ангилал, тодорхойлолт	-	ҮАМАТ-д нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.	ХНХ-ын сайдын 2023 оны 12 дугаар сарын 06-ны А/175 дугаар тушаалаар архив, түүнтэй холбогдох ажил, мэргэжилд нэмэлт, өөрчлөлт оруулсан. ҮАМАТ-08-ын цахим системд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулж байна.	50

иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ .	хийн шаардлагат ай ажил мэргэжлийг нэмэх, өөрчлөх, шинэчлэх	<p>өөрчлөлт оруулах</p> <p>Үндэсний индекс/кодоор үүсгэсэн 100-аас доошгүй ажил, мэргэжлийг сонгон авч тодорхойлолт, чиг үүрэг зэрэг холбогдох мэдээллийг боловсруулж, YAMAT-08-ын цахим системд цэс үүсгэн оруулах ажлыг эхлүүлэх</p>	батлах тухай” 16 дугаар тушаал		YAMAT-08 цахим системд цэс нэмэгдсэн байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/210 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон нийт 102 ажил мэргэжлээр тодорхойлолт боловсруулан гаргалаа. YAMAT-08-ын цахим системд ажил мэргэжлийн тодорхойлолтыг оруулах шинэ цэс нэмэх, цахим системд зарим сайжруулалт, өөрчлөлтийг хийлгэх Ажлын даалгавар боловсруулан Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-д хүргүүлсэн. Төслийн газраас тендер зарласан боловч шаардлага хангасан байгууллага орж ирээгүй тул цуцлагдсан байна.	
Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ .	2.9. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талтын хамтын ажиллагааг бэхжүүлэх	<p>2023-2024 оны Улсын хэлэлцээрийг байгуулж, хэрэгжүүлэх</p> <p>Салбарын хэлэлцээрүүдийг хууль тогтоомжийн дагуу бүртгэх</p>	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Улсын хэлэлцээрийн хэрэгжилт 80 хувь	-	Хэрэгжилт 40%	<p>Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2021-2022 оны улсын хэлэлцээрийн биелэлтийг гурван талт ажлын хэсгээр гарган, Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлж, талуудад хүргүүлсэн. Хэлэлцээрийн хэрэгжилт 87 хувьтай гэж дүгнэгдсэн.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны Улсын хэлэлцээрийг 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдөр байгууллаа.</p> <p>Салбарын 12 хэлэлцээрийг хууль тогтоомжийн дагуу хянан бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Тухайлбал: боловсрол, эрүүл мэнд, иргэний</p>	100

						нисэх, соёл, тээвэр, уул уурхай, олборлолт, барилга зэрэг.	
2.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, уялдаа холбоог нь сайжруулах	ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг зохион байгуулах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байна. ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын 3 конвенцид нэгдсэн.	-	ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг боловсролын салбарт зохион байгуулсан байна.	Боловсролын салбарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг зохион байгуулах ажлын удирдамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулж, 2023 оны 03 дугаар сарын 31-ний 03/826 тоот албан бичгээр аймаг, нийслэл дүүрэгт, чиглэл хүргүүлж ажилласан. Улсын үзлэгт нийт 21 аймаг, 9 дүүргийн мэргэжлийн боловсролын 77 байгууллага, үүнээс өмчийн хэлбэрээр авч үзвэл төрийн-38, хувийн-26, их, дээд сургуулийн 13 байгууллага байна. ХАБЭА-н улсын үзлэгт мэргэжлийн боловсролын 58 байгууллага хамрагдсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн улсын үзлэгийн хүрээнд ХАБЭА-н удирдлага зохион байгуулалт-58,8%, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал-67,4%, ажлын орчин, ахуйн байрны эрүүл ахуйн нөхцөл-54,7% дүгнэгдэж улсын хэмжээнд 60,4% буюу хангалтгүй үнэлгээтэй байна. Улсын үзлэгийн тайланд үндэслэн тухай салбарт авч хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийн төслийг боловсруулж салбарын яаманд хүргүүлэн ажилласан.	100	
	Баталсан эрх зүйн баримт бичиг		-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан байна.	Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэгдэж байгаатай холбогдуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/214 дугаар тушаалаар байгуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд Дэлхийн банкны “Төсөв санхүүгийн		

						<p>тогтвортой байдлыг дэмжих” төслийн дэмжлэгтэйгээр хууль эрх зүйн актын зохицуулалт, уялдаа холбоог судлах дүн шинжилгээ хийж, дотоодын зөвлөхтэй хамтран ХАБЭА-н тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн 2023 оны 07 дугаар сарын 07-ний өдөр УИХ-аар батлуулж, тус хуулийг даган Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулсан.</p>
		ХАБЭА-н стандартыг шинэчлэн боловсруулах		-	<p>“Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний аргачлалын багц стандарт”-ыг шинэчлэн баталуулсан байна.</p>	<p>Ажлын байрны нөхцөлийн үнэлгээний аргачлалын багц стандартыг шинэчлэн боловсруулах, батлуулах” арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоотой хамтран MNS 5080:202x Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавих шаардлага, MNS 4990:202x Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжилд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ гэсэн стандартуудыг шинэчлэн Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн. Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны стандартчиллын Техникийн хорооны хурлаар 5 удаа хэлэлцүүлэн, санал авч батлуулав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр мөрдөгдөж байгаа стандартуудын талаар мэдээлэл, танилцуулга бэлтгэж, холбогдох удирдлагуудад танилцуулав.</p>
		Олон улсын хөдөлмөрийн байгууллагын		-	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 81, “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр

		н 2 конвенцид нэгдэх бэлтгэл ажил			хяналтын 81 дүгээр конвенц, Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын 129 дугаар конвенцид нэгдэх бэлтгэх ажлыг хангасан байна.	конвенцуудад Монгол Улс нэгдэн орох талаархи судалгааны үр дүнг танилцуулах, санал авах хэлэлцүүлгийг 4 дүгээр сард ХНХЯ, ХХҮЕГ, нийслэл дүүргийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар, хэлтсийн хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын 35 улсын байцаагчид, 11 дүгээр сард Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ХХААХҮЯ-ны 30 албан тушаалтныг оролцуулан 2 удаа зохион байгуулсан. Дээрхи конвенцуудад Монгол Улс нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад ХНХЯ-ны газар хэлтсийн дарга нараас санал авч, хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад санал авахаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт 01/2341 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Албан бичгийн дагуу яамдаас ирсэн саналыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Гадаад харилцааны, Хууль зүй дотоод хэргийн сайд нараар гарын үсэг зурж баталгаажуулахад бэлэн болгож, Салбарын хяналтын газрын даргад танилцуулсан.	
Зорилт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдли йг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ	2.11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн менежменти йн тогтолцоог боловсронгу й болгож, аж ахуйн нэгж	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын хувийг 6-7 хувиар бууруулах	ҮОМШӨ-ний тоо – 353 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	-	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг ААНБ-дад сургалт,	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд Аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж, дүгнэлт гарган зөвлөмж өгч байгаагаас гадна ХАБЭА-н сургалтыг зохион байгуулж ажиллаж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд бүртгэлтэй MNS ISO 17020 стандартын итгэмжлэлтэй, дараах 6	100

	байгууллагын түвшин дэх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлийг сайжруулах				сурталчилгаа зохион байгуулж, хяналт тавьж ажилласан байна.	<p>байгууллага ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв 2. Хэлт энд сэфти солушинс ХХК 3. Даблью эйч эй ХХК 4. Түмэн тэрэм ХХК 5. Хэлт сэфти энд фрий воркплейсэс ХХК 6. Эв их глук ХХК <p>Дээрх байгууллагууд 2023 оны 12 сарын 13-ны байдлаар 191 аж ахуйн нэгж, байгууллагын 3017 ажлын байранд хэмжилт үнэлгээ хийж, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах тухай зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> • 2023 онд ХАБЭА-н сургалтын бүртгэлийн гэрчилгээ бүхий 123 байгууллага байгаагаас 97 сургалтын байгууллага тогтмол үйл ажиллагаагаа явуулж, тайлан өгсөн байна. Эдгээр байгууллага нь давцсан тоогоор 513 аж ахуйн нэгж, байгууллагын 218518 хүнд ХАБЭА-н сургалтыг зохион байгуулсан байна. Сургалтыг ангилвал: <ol style="list-style-type: none"> 1. Ажил олгогчийн сургалт – 3292 2. ХАБЭА-н асуудал хариуцсан сургалт – 3252 3. Ажилтны сургалт – 88208 4. Өндөр эрсдэлийн сургалт – 31899 5. Тусгай сургалт – 75911 6. Олон нийтийн сургалт – 15916 байна. <p>Мөн ХАБЭА-н урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”, “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” арга хэмжээг жил бүр 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.</p>
--	---	--	--	--	---	--

						Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар төрөөс баримталж буй бодлогыг танилцуулах, сурталчлах зорилгоор "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний II чуулган"-ыг Төрийн ордонд 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Чуулганаас гарсан зөвлөмжийг 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулан, 45 дугаар тэмдэглэл гаргуулан холбогдох байгууллагуудад 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02/3159 албан тоотой хүргүүлэв.	
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 3: НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГО							
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1: НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОДЛОГО							
Зорилт 3. Зорилтот иргэн, даатгуулагч ид нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэж, нийгмийн баталгаагаар хангана.	3.1. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлж, нийгмийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангасан нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл хийх	Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол,	Нийгмийн даатгалын багц хуулийг 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 26 удаа нэмэлт өөрчлөлт орсон.	-	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.	-Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл буюу Нийгмийн даатгалын ерөнхий, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шатлгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг тус тус 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан. Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжсэнээр олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн даатгалын тогтолцоог хуваарилалтаас хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжүүлэх, хуримтлал үүсгэх, тэтгэврийн даатгалын нэрийн дансны хийсвэр бичилтийг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогоос өвлүүлэх зэрэг томоохон өөрчлөлтийг хийх хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн. - Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг УИХ-ын 2023 оны намрын	100

		<p>мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх</p> <p>-Хуулийн төслийн тоо-5</p>				<p>чуулганаар батлахаар ажлын хэсэг ажиллаж байна. Үүнд:</p> <p>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 1 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг дэмжсэн. УИХ-ын 2023 оны намрын чуулганаар Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах үүднээс Нийгмийн бодлогын байнгын хорооны дэд ажлын хэсэг 12 удаа хуралдсан. Мөн Улсын Их хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар уг хуулийг хэлэлцсэн.</p>	
3.2.	<p>Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх тэй холбоотой тогтоол, журам, дүрэм, заавар, аргачлалыг боловсруулж батлуулах</p>	<p>Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тогтоол, журам, дүрэм, заавар, аргачлал боловсруулж батлуулах</p>	<p>Хууль хэрэгжүүлэх явцад дүрэм журмыг өөрчлөх шийдвэрийн төслийг тухай бүрт боловсруулж батлуулдаг.</p>	-	<p>Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тогтоол, журам, дүрэм, заавар, аргачлал боловсруулж батлуулсан байна.</p>	<p>Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг тус тус хэлэлцэн баталсан.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг байгуулах, хуваарь батлах тухай” 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/176 дугаар</p>	90

						<p>тушаалаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэх журам, заавар, дүрэм, аргачлал боловсруулж батлуулах ажлын хэсгийг байгуулсан.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан УИХ-ын байнгын хороогоор батлуулж буй-2, Засгийн газрын тогтоолоор батлуулсан-13, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар батлуулсан - 9, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар батлуулсан-8, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бусад яамдтай /Гадаад харилцааны яам, Эрүүл мэндийн яам/ хамтран баталсан-6, Нийгмийн даатгалын ерөнхий газрын баталсан-7, нэмэлтээр батлуулсан 5 дүрэм, журам /Үнд: Засгийн газрын тогтоолоо- 3, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар-2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан-1/ тус тус байна. Нийт 67 дүрэм, журам батлагдахаас 49 дүрэм, журам батлагдаад байна.</p>	
3.3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх	Тэтгэврийн нэмэгдлийн хувь	Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 350.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 300.0 мянган төгрөг, Дундаж тэтгэвэр-418.0 мянган төгрөг	-	Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээ-500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ-400.0 мянган төгрөг болсон байна.	Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 10 хувиар нэмэгдүүлж, нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 550.0 мянган төгрөгт, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 440.0 мянган төгрөгт тус тус хүргэж нэмэгдүүлсэн. Дээрх арга хэмжээний хүрээнд нийт 486.0 мянган тэтгэвэр авагчийн	100	

						тэтгэвэр нэмэгдэж, дундаж тэтгэвэр 687.0 мянган төгрөгт хүрсэн.	
	3.4. Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талууд (нийгмийн даатгалын салбарын ажилтан, албан хаагчид, ажил олгогч, иргэд, даатгуулагч) -ын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, хамралтыг нэмэгдүүлэх	Нийгмийн даатгалын хамралтын хувь	Албан журмаар даатгуулагч- 953.4 мянга Сайн дураар даатгуулагч- 193.1 мянга	Албан журмын даатгуул агчийн тоог 5-аас багагүй хувиар, сайн дурын даатгуул агчийн тоог 5-аас багагүй хувиар нэмэгдү үлсэн байна.	Албан журмын даатгуулагчийн тоог 5-аас багагүй хувиар, сайн дурын даатгуулагчийн тоог 5-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна.	Нийгмийн даатгалд албан журмын журмаар 2020 оны байдлаар 953.4 мянган даатгуулагч даатгуулж хамрагдаж байсан бол 2023 оны 12 дугаар сарын байдлаар 1 157.4 даатгуулагч хамрагдаж 21 хувиар өссөн байна. Нийгмийн даатгалд сайн дураар 2020 оны байдлаар 193.1 мянган даатгуулагч даатгуулж хамрагдаж байсан бол 2023 оны 12 дугаар сарын байдлаар 158.6 даатгуулагч хамрагдаж 17 хувиар буурсан байна.	50
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2: НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН БОДЛОГО							
Зорилт 3. Зорилтот иргэн, даатгуулагч ид нийгмийн хамгааллын үйлчилгээг	3.5. Зорилтот өрх, иргэдийн амьдралын нөхцөл, амьжиргаан	Нийгмийн халамжийн тухай хууль, Хүн амын өсөлтийг дэмжих тухай	2012 оноос хойш хууль шинэчлэгдээгүй	-	Нийгмийн халамжийн тухай хууль, Хүн амын өсөлтийг дэмжих тухай хуулийн төслийг Засгийн газрын	Нийгмийн халамжийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох яамдаас саналыг авч нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 1/2831 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2022 оны 8 дугаар сард Засгийн газрын бүтэц,	50

<p>хүргэж, нийгмийн баталгаагаар хангана.</p>	<p>ы түвшинг дээшлүүлэх оновчтой арга зам бүхий халамжийн бодлогын шинэчлэл хийх</p>	<p>хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх</p>			<p>хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.</p>	<p>бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотой Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ЗГХЭГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн ХЭГ/1996 дугаар албан бичгээр буцаан ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан яам, агентлагийн ажлын хэсэг 2023 оны 3-4 дүгээр сард Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дахин сайжруулах, холбогдох баримт бичгийн тоо мэдээллийг шинэчилж Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцоог дахин боловсруулж ажиллав.</p> <p>2023 оны 9 дүгээр Дэлхийн банкны ТСТББТ-ийн хүрээнд Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэл дээр дотоодын зөвлөхийг ажиллаж байна. Энэ хүрээнд дээрх хуулийн төслүүд дээр ажиллаж саналын хувилбарыг боловсруулсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд шинээр орсон хуулийн хэрэгжилтийн үнэлгээний судалгаа болон дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцооллыг боловсруулахад хамтран ажилласан. Хуулийг төслүүдийг 2023 оны 11 дүгээр сарын 15,16-ны өдөр ХХҮЕГ-аас зохион байгуулсан 21 аймаг, 9 дүүргийн халамжийн сан, олголт хариуцсан мэргэжилтнүүдэд, 23, 24-ний өдөр Багануур, Хэнтий аймгийн ХХҮ-ний газар, хэлтсийн мэргэжилтэн, сум, хорооны нийгмийн ажилтнуудад, 12-р сард нийслэлийн төсвийн 6 дүүрэг болон ШШГЕГ, СЭМҮТ, ОБЕГ, мэргэжлийн холбоод зэрэг бусад оролцогч талуудаар хэлэлцүүлж санал авч тусгалаа.</p>
---	--	---	--	--	---	---

						<p>Мөн түүнчлэн халамжийн тогтолцооны өнөөгийн байдал, шинэчлэх хэрэгцээ шаардлага болон шинэчлэлийн үзэл баримтлалын талаар бодлого боловсруулагчдад зориулсан гарын авлагыг боловсруулж хэвлэхэд бэлэн болгов.</p> <p>Хуулийн төслүүдийн үзэл баримтлалын төслийг ХНХ-ын сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01/3416 дугаар албан бичгээр Сангийн болон ХЗДХ-ийн яаманд дахин батлуулахаар хүргүүллээ.</p>
	Амьжиргаан нь дээшилсэн өрхийн тоо	Сонгогдсон өрхийн амьжиргааг дэмжих тусгайлсан хөтөлбөр байгаагүй	ОУБ-1.7 сая ам. доллар	Зорилтот өрхийг чадавжуулах халамжийн үйлчилгээг АХБ-ны төслийн дэмжлэгтэйгээр нийслэлийн 3 дүүрэгт туршин хэрэгжүүлсэн байна.	<p>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ын хүрээнд “Төгсөлтийн аргачлал” туршилтын хөтөлбөрийг нийслэлийн Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд 2022 оны 6 дугаар сараас эхлэн нийслэлийн ЗДТГ, Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж байна. 2023 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.</p> <p>-АйАрЭм судалгааны байгууллагын оролцоотойгоор зах зээлийн судалгааг 2022 оны 12 дугаар сараас эхлүүлж, сонгогдсон өрхүүдийн эрхлэх боломжтой аж ахуй эрхлэлтийн урт болон богино жагсаалтыг гаргуулах ажлыг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэв. Уг судалгааны дүнд хөдөлмөр эрхлэх боломжтой 24 чиглэлийг тодорхойлж, тухайн чиглэл бүрээр нарийвчилсан тооцоолол, судалгаа гаргасныг 2023 оны 5 дугаар сард хүлээн авсан.</p> <p>-Туршилтын хөтөлбөрийн хүрээнд баримтлах “Төгсөлтийн шалгуур үзүүлэлтүүд”-ийг эцэслэн боловсруулж, Төслийн захирлаар батлуулсан.</p> <p>-Сонгогдсон өрхүүдийн хөдөлмөр эрхлэхэд бэлэн байдлын (бизнес профайлинг) үнэлгээг</p>	

					<p>хийж, тэдний нийгмийн идэвх оролцоог сайжруулах тэдэнд тохирох бизнесийг санал болгож түүнд нь зохих дэмжлэг үзүүлэх зорилгоор бүлгийн болон цогц сургалт, уулзалтууд, улмаар судалгааг 4 дүгээр сард зохион байгуулсан.</p> <p>-Бизнес профайлинг хийсний үр дүнд хөтөлбөрт хамрагдах 1520 өрхөөс нийт 1281 өрх орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх бизнес сонголтыг хийсэн. Харин өрх ямар нэг бизнес сонгоогүй 241 өрх байна.</p> <p>Бизнес эрхлэх хүсэлтэй 1281 өрхөд орлогоо нэмэгдүүлэх, тухайн өрхөд бизнес эрхлэхэд шаардагдах орлого олох зориулалт бүхий тоног төхөөрөмжийг худалдан авах олгох ажлыг зохион байгуулан ажилласан. Өнөөдрийн байдлаар Монголын улаан загалмай нийгэмлэг нь хөтөлбөрт хамрагдсан 1,277 өрхийн гишүүний ур чадварыг хөгжүүлэх, чадавхжуулах, сургалтуудыг хийж, оёдлын үйлдвэрлэл, хоол, хүнс цагаан идээ, хүнсний ногоо хэрчиж, савлах үйлдвэрлэл, хүлэмжийн ногоо тариалах тоног төхөөрөмж зэрэг 12 төрлийн багц тоног төхөөрөмжийг олгоод байна.</p> <p>Бизнес эрхлэх хүсэлтэй 1281 өрхөд орлогоо нэмэгдүүлэх, тухайн өрхөд бизнес эрхлэхэд шаардагдах орлого олох зориулалт бүхий тоног төхөөрөмжийг худалдан авах олгох ажлыг зохион байгуулан ажилласан. 2023 оны 12 дугаар сарын байдлаар хөтөлбөрт хамрагдсан 1220 өрхөд оёдлын үйлдвэрлэл, хоол, хүнс цагаан идээ, хүнсний ногоо хэрчиж, савлах үйлдвэрлэл, хүлэмжийн ногоо тариалах тоног төхөөрөмж зэрэг 12 төрлийн багц тоног төхөөрөмжийг олгосон.</p>	
--	--	--	--	--	---	--

	<p>3.6. Нийгмийн халамжийн багц хуулийг хэрэгжүүлэх журам, дүрэм заавар, аргачлалыг боловсронгуй болгох, шинэчлэх</p>	<p>Зорилтот өрхийг сонгох аргачлал батлуулж, мэдээллийн сан үүсгэх нөхцөлийг хангах</p>		<p>-</p>	<p>Зорилтот өрхийг аргачлалын дагуу мэдээллийн санг бүрдүүлж ашигласан байна.</p>	<p>Засгийн газраас төрийн байгууллагуудын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрд цугларсан их өгөгдлийг төрийн бодлого шийдвэрт ашиглах, төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох эрх зүйн орчин бүрдэж эхэлсэнтэй холбоотойгоор өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Ингэхдээ төрд байгаа мэдээлэлд суурилан өрхийн орлогыг орлуулан тооцох боломжтой, өрхийн амьжиргаанд нөлөө үзүүлэхүйц мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлэх боломжийг бүрдүүлэхээр зорьсон.</p> <p>"Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал", "Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал"-ыг тус тус боловсруулж Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/14, А/04 дүгээр хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан. Энэхүү аргачлалыг шинэчлэн батлахдаа 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээллийг үндсэн мэдээлэл болгож ашигласан бөгөөд үүн дээр нэмж төрийн мэдээллийн санд бэлэн байгаа, хууль, эрх зүйн орчны хүрээнд ашиглах боломжтой өрх, иргэний мэдээллийг регистрийн дугаараар холбон холимог мэдээллийн сан үүсгэсэн. Уг аргачлалд Орлогыг орлуулан тооцох арга зүйг хэвээр ашигласан хэдий ч ашигласан мэдээллийн эх үүсвэр нь холимог байгааг харгалзан ООТА-аар өрхийн амьжиргааны түвшинг</p>	<p>100</p>
--	---	---	--	----------	---	---	------------

			3 жил тутамд шинэчлэх аргачлал 2016 оноос хойш шинэчлэгдээгүй			<p>тодорхойлох Хосолмол аргачлал гэж нэрлэсэн. Уг аргачлалын дагуу хүүхдийн мөнгийг 91 хувьд олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p>	
	<p>3.7. Зорилтот бүлгийг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох, шинэчлэх, аргачлалын дагуу амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэхэд нэгдсэн удирдлагаар арга зүйгээр хангах</p>					<p>Аргачлалын дагуу хүнсний эрхийн бичигт хамрагддаг 26.9 мянган өрхөөс судалгаа авах ажлыг 2023 оны 5 дугаар сард зохион байгуулж ажилласан. Энэ хүрээнд: -Орлогыг орлуулан тооцох аргачлал /ООТА/-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/36 дугаар тушаалыг батлуулсан. -Уг тушаалын дагуу судалгааг АХБ-ны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл-2”-ийн батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулахаар ажлын удирдамж, төсвийн тооцооллыг бэлтгэж, АХБ болон Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлсэн. -ООТА-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 26,900 өрхийг хамруулан улсын хэмжээнд 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр эхлүүлсэн. -Зөөврийн төхөөрөмжид зориулсан судалгааны программыг үндсэн системийн хамт ашиглалтад оруулж, 21 аймаг, 9 дүүргийн ХХҮГ/ХХҮХ-ийн дарга, мэргэжилтэн болон судалгааны багийн гишүүдэд программ хангамжийн сургалтуудыг танхим болон цахимаар зохион байгуулав. Мэдээлэл технологийн ажилтнуудад pmt2022 систем болон түүний хэрэглэгчийн болоод судалгааны модулийн ашиглалтын сургалтыг 5 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар 5 удаа зохион байгуулсан.</p>	100

						<p>Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд 26,900 өрхийн жагсаалтыг бэлтгэсэн. Өрхийн жагсаалтад орсон өрхүүдийг тоологчид хуваарилах болон газрын зурагт тэмдэглэх ажлуудыг хийлгэсэн.</p> <p>-Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтан болон багийн ахлагч/сургагч багшийн сургалтын бэлтгэлийг хангаж, сургалтыг 5 дугаар сарын 11-13-ны өдөр 70 хүнийг хамруулан, Улаанбаатар хотод танхимаар, тоологчийн сургалтыг аймаг, дүүргийн ХХҮГ/ХХҮХ нь аймаг, дүүргийн хэмжээнд 5 дугаар сарын 21-23-ны өдөр 700 орчим тоологч, ахлагчийг хамруулж танхимаар (хувь зөвлөх цахимаар зөвлөж, чиглүүлж, зарим бүсэд дахин сургалт хийсэн) зохион байгуулсан.</p> <p>-Судалгааны урьдчилсан дүнгээр нийт хамрагдах өрхийн 99.1% хамрагдсан байгаа бөгөөд цаашид төрийн бусад байгууллагаас шаардлагатай мэдээллийг авч өрхийн амьжиргааг үнэлэх ажил хийгдэх юм.</p> <p>2024 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс шинэчилсэн аргачлалаар өрхийн амьжиргааг тооцон мөн үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах зорилтот бүлгийг тодорхойлохоор ажиллаж байна.</p>	
3.8.	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинтэй уялдуулан	Тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдлийн хувь	2020 оны Тэтгэврийн хэмжээ- 188.000 төг, Тэтгэмжийн хэмжээ- 84.500 төг, 123.100	Улсын төсөв; 2022 онд 119.5 тэрбум.т өг 2023 онд: 239.1	Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн хэмжээгээр үргэлжлүүлэн олгосон байна.	Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн 288 мянган төгрөгөөр олгохоор “Тогтоолд өөрчлөлд оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2023 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 3 дугаар тогтоолоор батлуулав. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 288 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 70 мянга гаруй зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн	100

	жил бүр нэмэгдүүлэх			тэрбум.т өг		<p>баталгааг хангах боломж бүрдсэн. Нэмж шаардагдах 109.5 тэрбум хөрөнгийг 2023 оны халамжийн сангийн төсөвт тусгасан. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхээр 2023 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлаар 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн батлуулсан. Мөн Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг дараах байдлаар шинэчлэн тогтоов. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Нийгмийн халамжийн тэтгэвэр 288 мянгаас 325 мянган төгрөг, -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 288 мянгаас 325 мянган төгрөг, -Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэний тэтгэмж 84.5 мянгаас 275 мянган төгрөг, -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэний тэтгэмж 123.1 мянгаас 275 мянган төгрөг. <p>Нэмэгдэлийн хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 12.3%, 2020 оноос хойш нэмэгдээгүй байсан асаргааны тэтгэмжийн хэмжээ 2.2-3.2 дахин нэмэгдэв. 2023 онд Хүн амын амьжиргааны түвшин бүсүүдийн дундаж 282,880 төгрөг байгаа ба тэтгэврийн хэмжээ энэ оны 7 сараас нэмэгдсэнээр АДТ-ээс 12.9 хувиар илүү болсон.</p>	
	3.9. Нийгмийн	Платформд байрлуулсан	-			1. Нийгмийн халамжийн салбарын ажилтнуудыг тасралтгүй сургах хүний	

	<p>даатгал, нийгмийн халамжийн хүний нөөцийг чадавхжуулах сургалтын платформ, хөтөлбөрийг боловсруулж, салбарын ажилтан, албан хаагчид, гэрээт төрийн бус байгууллагыг чадавхижуулах</p>	<p>сургалтын модуль, болон түүнийг ашиглан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо</p>		<p>ОУБ:80.0 мян.ам.доллар</p>	<p>Салбарын албан хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр, модуль боловсруулж, цахимд нэвтрүүлсэн байна.</p>	<p>нөөцийн онлайн модуль боловсруулах дотоод зөвлөх үйлчилгээ үзүүлэх Улаанбаатар ньюс ХХК-тай ХНХЯ хамтран ажиллав. Энэ хүрээнд тус байгууллагаас боловсруулсан 6 үндсэн багц сэдвийн /1. Нийгмийн халамжийн түүх, бодлого хэрэгжилт, 2. Хувь хүний хөгжил стресс менежмент, 3. Нийгмийн ажлын удирдлага, 4. Үр дүнтэй нийгмийн халамжийн тогтолцоо, Нийгмийн халамжийн цахим шилжилт, 5. Ядуу өрх, иргэнтэй ажиллах төгсөлтийн аргачлал, 6. Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох орлогыг орлуулан тооцох шинэ аргачлал/ онлайн сургалтын контент, гарын авлага, материалуудыг хянан үзэж, сайжруулж ажилласан. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх ВЭБ-д суурилсан үнэлгээний дотоод хяналтын системийг халамжийн салбарт нэвтрүүлэв. Ингэснээр 21 аймаг 330 сум, 9 дүүргийн 200 орчим хорооны нийгмийн ажилтнуудын үзүүлсэн үйлчилгээнд иргэд сэтгэл ханамжаа 1-5 оноогоор киоск машинаар болон ВЭБ сайтаар дамжуулж үнэлгээ өгдөг болсон. Энэхүү 2 ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар ХХҮЕГ-т чиглэл хүргүүлж ажиллав. 2. Нийгмийн даатгалын салбарын ажилтнуудыг тасралтгүй сургах зорилгоор ХНХЯ-наас баталсан 6 үндсэн багц сэдвийн хүрээнд /1.Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоо, түүхэн замнал, үнэт зүйлс; 2. Нийгмийн даатгалын тогтолцоо, эрх зүйн орчин, шинэчлэлийн зорилтууд; 3.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, үнэлгээ хийх арга зүй; 4. Нийгмийн даатгалын</p>	<p>70</p>
--	--	--	--	-------------------------------	--	---	-----------

						байгууллагын ажилтан, албан хаагчийн үйлчилгээ үзүүлэх арга зүй; 5. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх; 6.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт/ онлайн видео хичээлийн контент бэлтгэж дууссан. Онлайн хичээлүүдийг НДЕГ-ын онлайн сургалтын платформд байршуулахад бэлэн болгоод байна.	
	3.10. Нийгмийн халамжийн хууль тогтоомжийн талаар иргэд, олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах зорилгоор мэдээлэл, сурталчилганы ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Нийгмийн халамжийн шинэчлэлийн талаар нийтлэл, нэвтрүүлэг, ярилцлага шторк бэлтгэж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх	-	-	Нийгмийн халамжийн шинэчлэлийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэх хүрээнд ТВ, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, төлөвлөгөө боловсруулсан байна.	-Нийгмийн халамжийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд олон улсын байгууллагатай хамтран ажиллсан. Үүнд Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр иргэд хүүхдийн мөнгөн тэтгэмжид хэрхэн цахимаар хамрагдах, хүсэлт гаргах арга замыг заах сурталчлан таниулах зорилгоор олон нийтэд чиглэсэн заавар, дэлгэрэнгүй танилцуулга, видео шторк, постер хийж түгээсэн. -Дэлхийн банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд ажиллаж байгаа зөвлөхийн хамт зорилтот хэсэгт чиглэсэн нийгмийн халамжийн эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор олон нийтэд болон бодлого боловсруулагчдад зориулсан Нийгмийн халамжийн шинэчлэл 2 төрлийн танилцуулга, боршур, Нийгмийн халамжийн үр нөлөөний шинжилгээ, судалгааны тайлан, Нийгмийн халамжийн түүхэн хөгжил номын агуулгыг боловсруулсан. Эдгээр ном, гарын авлагыг сонгон шалгарсан хэвлэлийн байгууллагаар тус бүр 300-500 хувь хэвлүүллээ.	90
ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 4: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ХАНГАХ, САЛБАРЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ							
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							

Зорилт 4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын удирдлага, манлайллыг төгөлдөржүүлнэ.

<p>Зорилт 4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын удирдлага, манлайллыг төгөлдөржүүлнэ.</p>	<p>4.1. Хүний нөөцийг чадавхижуулж, хөгжүүлэх замаар салбарын үйл ажиллагааг сайжруулах</p>	<p>Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг батлан, хэрэгжилтийг ханган ажиллах</p>	<p>ХНХЯ-ны төрийн албан хаагчийн “Сургалтын төлөвлөгөө”-г ЗГХЭГ, Удирдлагын академийн 2020 оны сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан батлуулж 55 албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамруулж, 5 сургалтыг зохион байгуулсан.</p>	<p>Улсын төсөв ОУБ-ууд, төсөл хөтөлбөрийн санхүүжилт</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023 оны сургалтын төлөвлөгөөнд газруудын саналыг тусган, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.</p>	<p>ХНХЯ-наас өөрийн үйл ажиллагаагаа сайжруулахын тулд тасралтгүй суралцаж, суралцах шинэ арга барилыг идэвхтэй хэрэглэдэг “Суралцагч байгууллага” болон төлөвших зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2023 онд мэргэшүүлэх сургалтад хамрагдах албан хаагчдын тооцоо судалгааг салбарын хэмжээнд гаргасан бөгөөд Тэргүүн түшмэлийн сургалтад 1, Эрхэлсэн түшмэлийн сургалтад 7, Ахлах түшмэлийн сургалтад 29, дунд хугацааны давтан сургалтад 10, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад 10 нийт 56 албан хаагчийг суралцуулсан байна.</p> <p>Нийт албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, хэрэгцээг хангах иж бүрэн тогтолцоо бий болгон яамны эрхлэх асуудлын хүрээнд 30 гаруй албан хаагч гадаадад улсад богино хугацааны сургалтад хамрагдсан байна.</p> <p>Мөн Төрийн албаны зөвлөлөөс 2023 онд зохион байгуулсан Пүрэв гарагийн Вэбинар сургалтад Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга гишүүд, Харьяа байгууллагын Захиргаа удирдлагын газар (хэлтэс)-ын дарга, хүний нөөцийн ажилтан, холбогдох албан хаагчдыг хамруулах ажлыг тухай бүх зохион байгуулж ажилласан.</p> <p>Төрийн албан хаагчдыг хөгжүүлэх ажлын хүрээнд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төрийн албан хаагчийг Япон улсын их дээд сургуулийн магистр, докторын түвшинд суралцуулдаг “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр”-ийн магистрын</p>	<p align="center">100</p>
---	---	--	--	--	---	--	---------------------------

						<p>сургалтад хамрагдсан 3 албан хаагчтай гурвалсан гэрээ байгуулж, суралцах хугацаанд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомжийн дагуу төлж байна.</p> <p>Нийт албан хаагчдад ажлын байран дахь эерэг зөв хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, хүмүүс хоорондын харилцааг дэмжих, харилцан ойлголцох нөхцөл байдлыг бүрдүүлэх, хамтын ажиллагааны дэвшилттэй арга барил, арга хэрэгсэл бий болгох, хүмүүс хоорондын харилцааг идэвхжүүлэх уур амьсгалыг эрүүлжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх чиглэлээр төлөвлөгөөний дагуу сургалтуудыг Мэдээллийн цагаар сар бүр зохион байгуулан ажиллаж байна.</p>	
	<p>4.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах замаар салбарын албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах, мэргэших, мерит зарчмаар шатлан дэвших нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр /2021-2024/-ийн хэрэгжилтийг хангах</p>	<p>Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр /2016-2020/ хэрэгжүүлсэн.</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Хөтөлбөрийн, хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p>	<p><i>Албан хаагчдын ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулах хүрээнд:</i></p> <p>Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, ур чадвар, санал санаачилгыг харгалзан цалин хөлс, урамшууллын уян хатан, ил тод, шударга тогтолцоог бүрдүүлэхээр зорин ажиллаж байна.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу 2023 оны хагас жилээр 144 хүнд 536,6 сая төгрөгийг урамшуулалд олгосон байна.</p> <p>Ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн шахуу хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэн илүү цагаар ажилласан албан хаагчдад цалингийн санд багтаан илүү цагийн хөлсийг тооцож олгох Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар</p>	<p>100</p>

					<p>хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын дагуу 17 албан хаагчид илүү цагийн хөлсөнд 5.1 сая төгрөгийг тооцож олголоо.</p> <p>Дэвшилтэт шинэ технологийг ажилдаа нэвтрүүлэх, цаасгүй технологийг бий болгох хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, хяналт, удирдлагын цогц онлайн Abble системийг ашиглаж эхлээд байна.</p> <p>Ажпын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн офиссын стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.</p> <p>Ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн, албан хаагчдаас ажил үйлсээрээ бусдыгаа хошуучлан ажиллаж байгаа 1 албан хаагчийг Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, 5 албан хаагчийг Алтан гадас одонгоор, 8 албан хаагчийг Хөдөлмөрийн хүндэт медалиар, 1 албан хаагчийг Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр, 2 албан хаагч төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр, 9 албан хаагчийг Хөдөлмөрийн салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр, 3 албан хаагчийг Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр, 6 албан хаагчийг Яамны хүндэт жуух бичгээр тодорхойлон шагнуулсан байна.</p> <p>Засгийн газраас гаргасан "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийн хүрээнд яам өөрийн байрандаа ажилчдынхаа хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг байгуулж ажиллуулж байгаа бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд 37 дугаар цэцэрлэгийн салбар цэцэрлэгт 35 хүүхэд хүмүүжиж байна.</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>Албан хаагчдын амьдралын нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд байгууллагаас олгох, тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэх хүрээнд:</p> <p>Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл орон сууцаар хангах, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө нөөцийг яамны төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Төрийн албан хаагчдын хэрэгцээнд үндэслэн орон сууцны болон нөхцөлийг нь сайжруулах асуудлыг судлан, Төгс орчин ХХК-тай Хан-уул дүүргийн Буянт ухаа спорт цогцолбор, Буянт ухаа нисэх буудал 2-ын дунд төв замаас 100м зайд барих 196 айлын орон сууцанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр захиалгад хамруулах гэрээ байгуулж, захиалга өгөх албан хаагчдын судалгааг гарган, 13 ажилтан урьдчилгаа төлж, гэрээ байгуулсан.</p> <p>Төрийн албан хаагчдын хэрэгцээнд зуслангийн зориулалтын газар эзэмших, ашиглах, байшин барихад дэмжлэг үзүүлэн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Кувейтын аманд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагчдын амины хэрэгцээнд зуслангийн зориулалтын газар эзэмших, ашиглах зөвшөөрөл авч, кадастрын зураг хийлгэхээр дүүргийн Газрын албатай хамтран ажиллаж байна.</p> <p>Төрийн албан хаагчдын нийгмийн батлагааг хангах хүрээнд төрийн албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардалд өдрийн 3,0 мянга, өдрийн</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>хоолны мөнгөнд 12,0 мянган төгрөгөөр тооцон, сар бүр олгож байна.</p> <p>Мөн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шинээр гэр бүл болсон 1 ажилтанд 500,0 мянган төгрөг, ар гэрт нь гачигдал гарсан 9 ажилтанд 2.7 сая төгрөг, өөрийн зардлаар мэдлэг боловсролоо дээшлүүлэхээр их дээд сургуульд суралцаж байгаа 11 ажилтанд 5.5 сая төгрөг, шинээр байранд орсон 14 албан хаагчид 7.0 сая төгрөг, шинээр төрсөн хүүхэдтэй 3 ажилтанд 900,0 мянган төгрөг, 2023 оны шилдэг 11 ажилтанд тус бүр 1,0 төгрөгийн нийт 50 ажилтанд 32,2 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч болон албан хаагчийн гэр бүлд байнгын асаргаатай хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг бол тухайн албан хаагчийн ажлын цагийг богиносгох зохицуулалтыг байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд оруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p><i>Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд:</i></p> <p>Төрийн албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг жил бүр мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Энэ жилийн хувьд Хавдар судлалын Үндэсний төвтэй гэрээ байгуулан, албан хаагчдаа урдчилан сэргийлэх багц шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байгаа ба үзлэг, судалгааны дагуу төрийн албан хаагчийг системтэйгээр эмчлүүлэх, сувилуулах ажлыг хийхээр ажиллаж байна.</p>	
--	--	--	--	--	--	--

						Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлыг дэмжин, яамны албан хаагчдаа Улсын хоёрдугаар төв эмнэлэгт эрт илрүүлгийн оношлогоо, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, нийт 128 албан хаагч оролцлоо.	
ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2: САЛБАРЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СТАТИСТИК, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ							
Зорилт 5. Цахим шилжилтийг гүнзгийрүүлж, үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, ил тод нээлттэй хүргэнэ.							
Зорилт 5. Цахим шилжилтийг гүнзгийрүүлж, үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, ил тод нээлттэй хүргэнэ.	5.1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, урьдчилан сэргийлэх зөвлөгөөг цахимаар өгдөг болох	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, урьдчилан сэргийлэх зөвлөгөөг цахимаар өгдөг болох	“Блэйнд кэйр” аппликэйшнээр сэтгэл гутрал, хувь хүний хөгжил, стресс, хайр сэтгэл, ганцаардал, хосын харилцаа зэрэг асуудлаар 2022 оны 8 сарын байдлаар 1181 хэрэглэгчид үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээллийг өгсөн.	Төсөв: 100,0 сая төгрөг	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг цахимжуулах, урьдчилан сэргийлэх зөвлөгөөг цахимаар өгсөн байна.	“Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй иргэн, хүчирхийллийн хохирогчдод И-тусламж вэйб сайтаар дамжуулан цахим сэтгэл зүйн, хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, насанд хүрэгчтэй ажиллах кейс үйлчилгээ”-ний супервишн хэлэлцүүлгийг 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн салбар нэгжүүдийн мэргэжилтэн, ТХБ, НЦҮ-ний төвийн ажилтнуудад цахим хэлбэрээр 14 хоногт 1 удаа тогтмол зохион байгуулж, 8 удаагийн хэлэлцүүлэгт 203 мэргэжилтэн, нийгмийн ажилтан оролцуулж, 5 кейсийг бүрэн шийдвэрлэн, практик арга зүйн дэмжлэг үзүүлсэн.	70
	5.2. Иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг цахимжуулах	“Ejob” платформ-1;	Хөдөлмөр эрхлэлтийн 7 үйлчилгээг e-mongolia цахим системд холбосон.	Төсөв: Улсын төсөв болон бусад эх үүсвэрээр 1,7 тэрбум	“Ejob” платформыг бүрэн нэвтрүүлсэнтэй холбогдуулан гүйцэтгэгч байгууллагатай хамтран	Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэх зорилгоор Хиймэл оюун ухаанд суурилсан Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг 2022 онд хэрэглээнд нэвтрүүлж ашиглалтад оруулсан. “Ejob” платформ нь Онлайн	

				<p>хөгжүүлэлтийг хийж боловсронгуй болгосон байна.</p>	<p>портал, мобайл аппликэйшн, хөдөлмөрийн ажилтнуудын ажиллах хэсэг /back office/ гэсэн 3 дэд систем 13 модулиас бүрдэнэ. Системийн хүрээнд хэрэглэгч өөрийн анкет буюу CV-г байгууллагуудад илгээх, амьдарч буй байршлаас хамааран 1-10 км радиусын хүрээнд ажил хайх, байршлаас үл хамааран ажлын байртай болох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах боломжуудыг бүрдүүлсэн. Тухайлбал, гадаадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэн монголд байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудтай системээр дамжуулан холбогдож, гэрээт ажил, үүрэг гүйцэтгэх, мөн эх орондоо эргэж ирээд ажиллах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/204 дүгээр тушаалын дагуу холбогдох ажлыг хийж, “Ejob” платформын үйл явцын талаарх тайлан мэдээг 10 хоног тутам авч нэгтгэн үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад танилцуулж байна. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар “Ejob” платформд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Бүртгэлтэй ажлын байрны тоо-70293, 2. Ажил хайгчийн тоо-87466, 3. Ажил олгогчийн тоо-12063, 4. Ажилд зуучлагдсан иргэдийн тоо-19962, 5. Мобайл аппликэйшн хэрэглэгчийн тоо-29065 болсон байна. <p>Системийн нэвтрүүлэлттэй холбоотойгоор иргэд олон нийтэд таниулах ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээллийн цагаар нийт 64 албан хаагчдад, “Хүртээмжтэй хөдөлмөрийн өдөрлөг”, “Ажил олгогч байгууллагууд, хүний нөөцийн захирлуудтай хийсэн өглөөний уулзалт”, “Career expo-Залуучуудын өдөрлөг”, “Төрийн</p>	70
--	--	--	--	--	--	----

					<p>бус байгууллагуудын холбоо” зэрэг томоохон арга хэмжээ уулзалтад Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформын танилцуулга мэдээллийг хийж, 25113 ажил хайгч иргэн болон 2405 ажил олгогч байгууллага руу танилцуулга, мобайл аппликейшны холбоосыг масс мессэжээр илгээсэн.</p> <p>“Ejob” платформын баталгаат 18 сарын хугацаанд системийг сайжруулахад ХНХЯ, ХХҮЕГ болон гүйцэтгэгч байгууллага болох АйТиЗон ХХК-д мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилго бүхий мэдээллийн технологийн ахлах зөвлөх сонгон шалгаруулан ажиллаж байна.</p> <p>Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/176 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа болон бусад арга хэмжээг цахимжуулах талаар санал боловсруулж танилцуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн 6 удаагийн хурлаар нэгдсэн санал, дүгнэлт гаргаж холбогдох газар, хэлтэст чиглэл өгч биелэлтийг хангуулан үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад танилцуулсан.</p> <p>Түүнчлэн цагийн ажил зуучлалын үйлчилгээг цахимжуулах хүрээнд “Ejob” платформиор дамжуулах, төрийн байгууллагаас гаргасан хөдөлмөрийн цахим үйлчилгээ сурталчилж, гол функц болгон хөгжүүлэлтийг яаралтай хийж сайжруулахаар томоохон аж ахуйн нэгж байгууллага болон холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулан</p>	
--	--	--	--	--	---	--

						ажлын хэсгийг байгуулан санал боловсруулахаар ажиллаж байна. 2023 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээний тайлангийн 36 хөгжүүлэлт хийхээс 20 арга хэмжээний хөгжүүлэлтийг систем хөгжүүлэгч байгууллага хийж хүлээлгэж өгсөн ба үлдсэн 16 арга хэмжээг ондоо багтаан дуусгаж ашиглалтад оруулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.	
	5.3. Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах	Цахим үйлчилгээнд шилжүүлэх боломжтой нийт үйлчилгээний цахимжуулсан хувь	Нийгмийн даатгалын нийт 34 үйлчилгээнээс 14 үйлчилгээг цахимаар иргэдэд хүргэж байна.	-	Нийгмийн даатгалын 10 үйлчилгээг буюу 70 хувийг цахимжуулсан байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, И-Монгол академи хамтран “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт”-ыг e-Mongolia 3.0 системд 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр холбосон. 103 мянган иргэн энэхүү үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн. Нийгмийн даатгалын 34 төрлийн үйлчилгээний 24 үйлчилгээг нь цахимжуулсан. E-Mongolia цахим системд 16 үйлчилгээг холбосон e-Mongolia цахим системээс 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сар хүртэл 7.2 сая удаа нийгмийн даатгалын цахим үйлчилгээг авсан байна. Тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулж, иргэд, тэтгэвэр авагчдын тэтгэврийг цахимаар тогтоох, цахим хяналт, шалгалтыг сайжруулах, сумын төвөөс аймгийн төв рүү тэтгэврийн хувийн хэргийг шилжүүлэхгүй, зөөвөрлөх шаардлагагүй, нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүргэхээр баруун 8 аймгийн тэтгэврийн хувийн хэргийг 2022 оноос цахимжуулж эхэлсэн. 2023 оны 12 дугаар сарын байдлаар Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Ховд, Хөвсгөл, Увс аймгийн	100

						нийгмийн даатгалын хэлтэс нийтдээ 115,874 тэтгэврийн хувийн хэргээс 95 697 хувийн хэргийг цахимжуулж, цахимжилт 82.6 хувьтай байна. Үүнээс Увс, Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хувьд бүрэн цахимжуулж дууссан.	
5.4. Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн технологийн программ хангамжийг хөгжүүлэх	Мэдээллийн технологийн нэгдсэн нэг систем	НД-ын үйл ажиллагаанд 40 гаруй программ, хангамж ашиглагдаж байна.	-	Мэдээллийн технологийн нэгдсэн нэг системтэй болсон байна.	Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн технологийн нэгдсэн системийг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс нэвтрүүлж эхэлсэн. /portal.ndaatgal.mn/	100	
5.5. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах	Нийгмийн халамжийн цахим үйлчилгээнд шинжилгээ хийж, салбар дундын ажлын хэсэг байгуулан үйлчилгээнд гарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, үйлчилгээг сайжруулж, программд	Нийгмийн халамжийн 26 үйлчилгээг цахимаар иргэдэд хүргэж байна.	-	e-halamj.mn системийг ашиглахад иргэдээс шаардаж буй цаасан баримтын тоо багасаж, үйлчилгээ авахад иргэдэд чирэгдэлгүй болж, НХ-ийн ажилтнуудын ажлын ачаалал буурсан байна.	“Нийгмийн халамжийн нэгдсэн систем”-ийг 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс улсын хэмжээнд нэвтрүүлж эхэлсэн. Нийгмийн халамжийн цахимжуулсан үйлчилгээний тоо 14 байсан бол 2021 онд 12 үйлчилгээг, 2022 онд 48 үйлчилгээг нэмж цахимжуулснаар 2023 оны байдлаар нийт 64 үйлчилгээ буюу нийгмийн халамжийн бүх үйлчилгээг 100 хувь цахим хэлбэрт шилжүүллээ. Түүнчлэн цаг үеийн өөрчлөлт болон салбар хоорондын цахимжилтттай холбоотойгоор хавсралтаар оруулж байгаа цаасан материалыг бусад салбараас цахим хэлбэрээр авах зэрэг хөгжүүлэлт хийх, сайжруулах, ажлыг төлөвлөн ажиллаж байна.	90	

		<p>хөгжүүлэлт хийх хүрээнд: -Ажлын хэсгийн тушаал-1 -Хөгжүүлэлт хийсэн үйлчилгээний тоо</p>				<p>Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах, төрд байгаа мэдээлэлд тулгуурлан өрхийг үнэлэн халамжийн зарим үйлчилгээг иргэдэд хүргэх, УИХ-с нийт хүүхдийн 91%-д хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгох тотоолын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Аргачлал боловсруулах ажлын хэсгийг аргачлал боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангах хүрээнд:</p> <p>1. Үндэсний статистикийн хорооноос хүргүүлсэн жагсаалтын дагуу буюу Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд 2018, 2020 онуудад хамрагдсан нийт 32,000 өрхийн 150,000 гаруй иргэний мэдээллийг дараах төрийн 13 байгууллагын мэдээллийн сангуудтай тулгах ажлыг зохион байгуулж аргачлал боловсруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Үндэсний статистикийн хороо -Төрийн албаны зөвлөл -Боловсрол шинжлэх ухааны яам -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам -Монголбанк -Нийгмийн даатгалын ерөнхий газар -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар -Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар -Татварын ерөнхий газар -Улсын бүртгэлийн ерөнхий газар -Хил хамгаалах ерөнхий газар -Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК -Авто тээврийн үндэсний төв <p>Хууль эрх зүй орчины зохицуулалтын хүрээнд Өрхийн мэдээллийн нэгдсэн санг</p>	
--	--	---	--	--	--	---	--

					<p>удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ын төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.</p> <p>Өрхийн мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллүүдийг төрийн 12 байгууллагуудын мэдээллийн сангаас авч нэгтгэх ажлын хүрээнд</p> <p>-Өрхийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх зохиомол серверийг Үндэсний дата төв дээр үүсгэж төрийн мэдээллийн сүлжээнд холбосон. Тус серверт төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан холбогдох төрийн 5 /ҮСХ, УБЕГ, НДЕГ, ТЕГ, АТҮТ/ байгууллагын сүлжээний тохиргоонуудыг хийж байгууллагуудыг холбогдоход бэлэн болгосон.</p> <p>-Дээрх байгууллагуудаас 3,508,635 иргэний 28, 560,562 мөр мэдээлэл нэгтгэгдсэн</p> <p>-Дээрх мэдээллийг авсан талаарх мэдэгдлийг мэдээллийн эзэнд хүргэх нэгдсэн загварыг боловсруулсан.</p> <p>Хүүхдийн мөнгө олгохтой холбоотой зохион байгуулж байгаа бусад арга хэмжээ:</p> <p>-Өрхийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх системийн ерөнхий зураглалыг боловсруулсан.</p> <p>-eHalamj болон eMongolia системээр дамжуулан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг үйлчилгээний ажлын даалгаварыг боловсруулаж хөгжүүлэх байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>-Дээрх үйл ажиллагааны үр дүн 2023 оны 01-р сараас нийт 1.1сая хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж үйлчилгээг үзүүлсэн ба УИХ-ын шийдвэрээр 7-р сараас бүх хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох болсонтой холбогдуулан халамжийн нэгдсэн систем</p>
--	--	--	--	--	--

						ehalamj.mn болон төрийн үйлчилгээний нэгдсэн систем emongolia.mn-р дамжуулан хүүхдийн мөнгөн тэтгэмж авах үйчилгээг дээрх шийдвэртэй нийцүүлэн шинэчлэх ажлыг ЦХХХЯ, ХХҮЕГ, иМонгол акакед, Гаалт татварын мэдээлэл технологийн төвтэй хамтран хэрэгжүүлэв.	
	5.6. Салбарын судалгаа, шинжилгээн ий ажлыг зохион байгуулж, салбарын статистик мэдээллийг ашиглан, шинжлэх ухааны арга зүйгээр тооцож, судлах, түгээх	Салбарын бодлогын хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийх	2020 онд ХНХЯ-ны захиалгаар ХНХСИ болон гадаад, дотоодын судалгаа эрхэлдэг байгууллагууд аар 20 орчим судалгааг хийж гүйцэтгүүлсэн байна.	-	Салбарын бодлогын хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинжлэх ухааны үндэслэлтэй 7 судалгаа хийгдсэн байна.	Дэлхийн банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр нийгмийн халамж, нийгмийн даатгалын бодлогын дунд болон урт хугацааны үр нөлөөг төлөвлөх динамик загварын хөгжүүлэлтийг (программ хангамж) хийсэн. Энэ ажлын үр дүнд цаашид ХНХЯ болон түүний харьяа байгууллагын ажилтнууд нийгмийн халамж, даатгалын тооцооллын загварчлалыг ашиглан бие даан бодлогын хувилбар тус бүр дээр үр нөлөөний тооцоолол хийж бодлого боловсруулах үйл ажиллагаандаа ашиглах боломжтой болж байна. Тус газраас нийгмийн халамж, нийгмийн даатгалын бодлогын дунд болон урт хугацааны үр нөлөөг төлөвлөх динамик загварыг ашиглан дараах тооцоо, судалгааг хийлээ. • Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл боловсруулж батлуулахтай холбогдуулан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын хэтийн тооцоолол судалгаа • Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дахин сайжруулах, холбогдох баримт бичгийн тоо мэдээллийг шинэчилж Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж олгох, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, дагалдах хуулийн	100

						<p>төслүүд, тандан судалгаа, зардлын тооцоог дахин боловсруулсан бөгөөд хууль тогтоомжийн тухай хуульд шинээр орсон хуулийн хэрэгжилтийн үнэлгээний судалгаа болон дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцооллыг боловсруулахад хамтран ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> • Цалинтай ээж хөтөлбөрийн тэтгэмжийг 1 удаа олгоход гарах зардлын судалгаа • Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл боловсруулж батлуулахтай холбогдуулан нийгмийн халамжийн сангийн зарлагын хэтийн тооцоолол судалгааг хийж ажилласан. • Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны нөлөөллийг үнэлэх судалгаа • Ганц бие ахмад настны тэтгэврийн зарцуулалт, хүртээмжийн судалгаа • Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн үнэлгээний судалгаа 	
5.8. Салбарын мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах	“Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмын төслийг боловсруулах, хэрэгжилтийг хангах	Мэдээллийн аюулгүй байдлын түвшин сул байна.	-	Кибер аюулгүй байдлыг хангах журмын төсөл боловсруулсан байна.	Засгийн газрын 2023 оны 224 дугаар тогтоолоор “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”-ыг баталсаны хүрээнд тус нийтлэг журамд заасны дагуу “кибер аюулгүй байдлыг хангах журам”-ын төслийг боловсруулаад байна.	100	